

**Аудитыг гүйцэтгэсэн:**

Гүйцэтгэлийн аудитын газрын
захирал бөгөөд тэргүүлэх
аудитор

М.Давааням

Аудитын менежер:

З.Ариунзаяа

Аудитор

Д.Баатархуяг

М.Доржмаа

М.Гүнжмаа

И.Туяадарь

Б.Лхагвацэрэн

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар 261456
дугаарын утсаар харилцана
уу.

**Уг тайланг YAГ-ын цахим
хуудаснаас үзнэ үү.**
www.audit.mn

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-3,
Улаанбаатар-15160
Монгол Улс

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгт, зураг, бүдүүвчийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	6
Ерөнхий мэдээлэл	7-8
Бүлэг 1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй нь хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөг бууруулж, гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй байна	9-15
Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааны тогтолцоо бүрэн бүрдээгүйгээс холбогдох бодлого, зохицуулалт байнгын, тасралтгүй, нэгдмэл байж чадахгүй байна.	9-10
Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг хангалттай зохион байгуулж ирээгүй нь гэмт хэргийн гаралт буурахгүй байх эрсдлийг үүсгэж байна	10-11
Цагдаагийн алба хаагчдын ажлын ачаалал их байгаагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж хязгаарлагдаж байна	11
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн цагдаагийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд төсөв, хөрөнгийг зохицуулсан хуулийн харилцан нийцэлгүй заалтууд сөргөөр нөлөөлж байна	12-13
ХЗДХЯ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ТББ-уудтай байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээг дүгнэдэггүйгээс үр дүнг үнэлэх боломжгүй байна.	14-15
Төсвийг зориулалт бусаар зарцуулснаас шалтгаалж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжээгүй байна	15
Бүлэг 2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хамрах хүрээ, арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байна	17-22
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг өргөжүүлж арга хэлбэрийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна	17
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн туршлагуудыг дэмжих бодлого, эрх зүйн зохицуулалтгүйгээс хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна	17-19
Замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэх шаардлагатай байна	19
Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэлбэр оновчгүй байгаагаас гэмт хэргийн гаралт буурахгүй байна	19-20
Гэмт хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлж байгаа эрсдэлтэй цэгүүдийг хяналтад авч, цэгцлэх шаардлагатай байна	20
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна	20
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ажлын албаны үйл ажиллагаа тогтворгүй, байнгын бус, үйл ажиллагааг зохистой төлөвлөж ирээгүй нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байх шалтгаан болж байна	21-22
Засгийн газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийх шаардлагатай байна	22
Бүлэг 3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах ажлыг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна	23-28
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсвийг хуульд заасны дагуу батлаагүйгээс зорилтод үр дүнд хүрэх боломжийг хязгаарласан байна	23-24



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөв, санхүүжилттэй холбоотой заалтуудыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна	24
ХЗДХЯ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, батлаагүй, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж байгаагүйгээс 2015-2017 онд нийт зардлын 39.0 хувийг зориулалт бусаар зарцуулжээ	24-25
Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн байна	26
Аймаг, нийслэл, сум, дүүргийн цагдаагийн байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олгосон зарим санхүүжилтийг Төсвийн тухай хууль, ОНХС-ийн зааврыг зөрчиж олгосон байна	27-28
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн зарцуулалтад тавих хяналт сул байгаа нь батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна	28
ХЗДХЯ, УЕПГ-аас ирүүлсэн санал	29-42
ҮАГ-аас саналд өгсөн тайлбар	43-46
Дүгнэлт	47
Зөвлөмж	48
Хавсралт	49-51
Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас	52
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	53-54



Говчилсон үгийн жагсаалт

БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ГХУСТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТЯ	Зам тээврийн яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНЦ	Олон нийтийн цагдаа
ТББ	Төрийн бус байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТХХАБАЖ	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам
УИХ	Улсын Их Хурал
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ХЗДХС	Хууль зүй дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ЛҮСНЭГТИЙН ТОВЪЁГ

Хүснэгтийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Бүртгэгдсэн гэмт хэрэг тоон үзүүлэлтээр /2015-2017 он/	7
Хүснэгт №2	Бүртгэгдсэн гэмт хэрэг төрлөөр /2015-2017 он/	7
Хүснэгт №3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээр төлөвлөсөн ажил /2015-2017/	11
Хүснэгт №4	Үр дүнг хэмжих үзүүлэлтүүд	12
Хүснэгт №5	Үүсгэн байгуулагдсан болон ХЗДХЯ-тай гэрээ байгуулсан огноо нь ойролцоо ТББ-ууд	15
Хүснэгт №6	ГХУСТХ-д заасан аргуудын үнэлгээ	17-18
Хүснэгт №7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын туршлагыг хэрэгжүүлж байгаа байдал	18-19
Хүснэгт №8	Аймаг, нийслэлийн ИТХ-аас баталсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсөв /сая төгрөг/	23
Хүснэгт №9	Зориулалт бус зардлууд /сая төгрөг/	25

Зургийн товъёг

Хүснэгтийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг №1	Үр дүнг хэмжих үзүүлэлтүүдээр байгуулсан радар дүрслэл	12
Зураг №2	ОНЦ ажиллаагүй болон ажиллаж байгаа аймгуудын харьцуулалт	13

Бүдүүвчийн товъёг

Хүснэгтийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Бүдүүвч №1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан оролцогч байгууллагуудын бүтэц	8
Бүдүүвч №2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж буй бүтэц	9
Бүдүүвч №3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах санал болгож буй бүтэц	11

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг дараах 3 зорилтын хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлого төлөвлөлтийн газар, хэлтсүүд, ГХУСАЗЗ, түүний ажлын алба, Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, аймаг, нийслэлийн ИТХ болон бусад холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагааг 2015, 2016, 2017 оны эхний хагас жилийг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашигласнаас гадна Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд дурдсан аудитын арга зүйг мөрдөж аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор М.Доржмаа, Д.Баатархуяг, И.Туяадарь, М.Гүнжмаа, Б.Лхагвацэрэн нар гүйцэтгэлээ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайланг ерөнхий мэдээлэл, аудитын үндсэн зорилтын дагуу нэгдүгээр бүлгийг “Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй нь хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөг бууруулж, гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй байна”, хоёрдугаар бүлгийг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байна”, гуравдугаар бүлгийг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах ажлыг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэсэн нэртэйгээр бүлэглэн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн бүтэцтэйгээр бичсэн.

Аудитын хугацаа

Аудитыг 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг гүйцэтгэлийн аудитын журмын 8, 9, 10 дугаар маягтын дагуу бэлтгэж, ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын хүндрэл бэрхшээл

2012-2016 онд ГХУСАЗЗ-ийн ажлын алба татан буугдсан, 2015-2016 онд ажиллаж байсан ихэнх албан тушаалтнууд өөрчлөгдсөнөөс шалтгаалан ХЗДХЯ аудитад шаардлагатай баримт материалыг хугацаанд нь гаргаж өгөөгүйгээс аудитыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх боломжийг хязгаарласан.



Ерөнхий мэдээлэл

Гэмт хэргийн нөхцөл байдлын талаар

Монгол улсад жилд дунджаар 27.7 мянган гэмт хэрэг гарч, насанд хүрсэн 10.0 мянган хүнд 121 гэмт хэрэг ногдож, 2174 хүн нас барж, 27847 хүн гэмтэж, төр засаг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийт 537.3 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч байгаа нь бусад улс оронтой харьцуулахад гэмт хэргийн гаралтын түвшин дунджаар 50.6 хувиар өндөр байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 34.7 хувь нь орон нутагт, 65.3 хувь нь нийслэлд үйлдэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг, тоон үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №1 Бүртгэгдсэн гэмт хэрэг тоон үзүүлэлтээр /2015-2017 он/

Он	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн улмаас хохирсон хүн		Гэмт хэргийн улмаас учирсан хохирол /сая. төгрөг/		Гэмт хэрэгт холбогдсон хүн	
	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг	Нийслэл	Орон нутаг
2015	17393	9779	17550	10398	87,308.7	57,032.3	14511	10346
2016	17909	9222	18005	9684	117,174.6	45,734.8	14483	9323
2017.06.30 байдлаар	8289	4666	14501	4894	213,156.9	16,935.6	6325	4694
Нийт	43591	23667	50056	24976	417,640.2	119,702.7	35319	24363

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын 2015, 2016, 2017 оны хагас жилийн статистик мэдээ

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн хамгийн их буюу 32.7 хувийг хулгайлах, 29.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулсан хэргүүд эзэлж байна.¹ Гэмт хэргийг төрлөөр харуулбал,

Хүснэгт №2 Бүртгэгдсэн гэмт хэрэг төрлөөр /2015-2017 он/

№	Гэмт хэргийн төрөл	2015	Хувь	2016	Хувь	2017.06.30	Хувь
1	Хулгайлах	9169	33.0	9065	33.4	4114	31.7
2	Бусдын бие махбодид гэмтэл учруулах	8064	29.1	8248	30.4	3842	29.6
3	Залилан мэхэлж авах	2067	7.4	2165	7.9	1064	8.2
4	Танхайрах	1582	5.7	1449	5.3	698	5.4
5	ТХХАБАЖ зөрчих	1394	5.0	1291	4.7	771	4.2
6	Дээрэмдэх	537	1.9	474	1.7	230	1.8
7	Хүн амын эрүүл мэндийн эсрэг /мансууруулах бодисын хууль бус эргэлт/	341	1.2	416	1.5	41	0.0
17	Бусад	4270	11.1	4059	9.6	3050	15.7
18	Нийт	27757	100	27167	100	13810	100

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын 2015, 2016, 2017 оны хагас жилийн статистик мэдээ

Эрх зүйн орчны талаар

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг 1997 онд баталж, нийт 5 удаа /2012, 2013, 2015, 2016, 2017 онд/ өөрчлөлт оруулсан байна.

Цагдаагийн албаны, Прокурорын, Гэр бүлийн хүчирхийллийн, Хүүхэд хамгааллын, Хүн худалдаалахтай тэмцэх, Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эмийн хууль бус эргэлтэд хяналт тавих, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, Садар самуунтай тэмцэх, Архидан согтуурахтай тэмцэх, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай, Зөрчлийн, Эрүүгийн хуулиудын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 06 дугаар зарлигаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл” байгуулагдаж, түүний ажиллах журам батлагдсан. Мөн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлүүдийг байгуулж, үндэсний хөтөлбөрүүдийг баталсан байна. Үүнд:

¹ ЦЕГ-ын танилцуулга /2017.10.16/.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр
- Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр
- Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хууль сахиулах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд олон нийтийг хамруулсан өргөн цар хүрээтэй ажил байхаар хуульчлагдсан бөгөөд ХЗДХЯ, ЦЕГ, УЕПГ, бүх шатны ИТХ зэрэг байгууллагууд голлох байр суурьтай оролцож байна.

Бүдүүвч №1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан оролцогч байгууллагуудын бүтэц



Эх сурвалж: ГХУСТХ-д үндэслэсэн аудитын багаас бэлтгэсэн мэдээлэл

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэлбэрийн талаар

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12, 13, 14, 15-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дараах арга хэлбэрээр хэрэгжүүлэхийг заасан. Үүнд:

- Иргэдийг татан оролцуулах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах,
- Иргэдээс төлбөртэй мэдээлэл авах,
- Хорих ял эдлээд суллагдсан иргэнд захиргааны хяналт тогтоох.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн талаар

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг Засгийн газар жил бүр улсын төсөвт тусгайлан тусгаж байхаар заажээ. Үүний дагуу 2015 онд 607.9 сая төгрөг, 2016 онд 1,367.0 сая төгрөг, 2017 онд 1,800.8 сая төгрөгийг тус тус Хууль зүй дотоод хэргийн сайдын төсөвт тусгажээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх”-ээр заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд орон, нутгийн төсвөөс санхүүжүүлэн олгосон хөрөнгийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, зарцуулж иржээ. Энэ заалтын дагуу 2015 онд 4,720.4 сая, 2016 онд 6,830.8 сая, 2017 онд 6,655.0 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт тусгажээ.



Бүлэг 1

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй нь хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөг бууруулж, гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй байна

Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааны тогтолцоо бүрэн бүрдээгүйгээс холбогдох бодлого, зохицуулалт байнгын, тасралтгүй, нэгдмэл байж чадахгүй байна.

1.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1²-д заасны дагуу гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах шинжилгээ судалгааны ажлыг эрхлэх эрдэм шинжилгээний байгууллага Хууль зүйн сайдын дэргэд ажиллана³ гэсэн боловч уг байгууллага 2012 онд татан буугдсанаас хойш энэ чиг үүргийг эрхэлсэн нэгж байгуулагдаагүй өнөөг хүрснээс шалтгаалан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тогтолцоо хуульд заасны дагуу бүрдээгүй байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа өнөөгийн бүтцийг дүрслэн харуулбал:

Бүдүүвч №2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж буй бүтэц



Эх сурвалж: Аудитын багийн нэгтгэн боловсруулсан мэдээлэл

1.2 Дээрх дүрслэлээс харахад цагдаагийн байгууллага гэмт хэргийн тоо бүртгэл, статистик мэдээлэл боловсруулах чиг үүргийг зохих хэмжээнд хэрэгжүүлж байгаа боловч сүүлийн жилүүдэд хийгдэж байгаа эрх зүйн орчны шинэчлэлт, өөрчлөлттэй уялдуулан 2009 онд батлагдсан аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

² Гэмт хэргийн талаарх мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох.

³ ГХУСТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт.

⁴ Гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшин, хэв журмын нөхцөл байдлын талаар мэдээлэл боловсруулах, цагдаагийн байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах.

⁵ Улсын ерөнхий прокурорын газрын дэргэд эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, прокурорыг мэргэшүүлэх сургалт, судалгааны нэгж байна.

⁶ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах.

⁷ Мэдээлэл, судалгааны төвөөс сар бүр өсгөн нэмэгдүүлсэн дүнгээр гарган хүргүүлсэн статистикийн мэдээг үндэслэн хэрэг бүртгэх, ... судалгаа, дүн шинжилгээ хийж, мэдээлэл, танилцуулга бэлтгэх.

⁸ Гэмт хэргийн байдалд хамтран дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээний чиглэлийг тогтоох.

⁹ Гэмт хэргийн талаархи мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох.



1.3 Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах чиг үүргийг прокурорын болон цагдаагийн байгууллага давхардуулан гүйцэтгэж байгаа нь хөрөнгө, нөөцийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсгэж байна.

1.4 Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн судалгааг нэгтгэх, нэгдмэл байдлаар дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, бодлого боловсруулах чиг үүргийг орон тооны бус бүтцэд харьяалуулснаас шалтгаалж, тус үйл ажиллагаа байнгын бөгөөд тасралтгүй ажиллаж чадахгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар нэгдмэл бодлогогүй байна.

1.5 Тиймээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх өнөөгийн удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийн уялдааг өөрчлөн, зохих хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байнгын, тасралтгүй, үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй байна.

1.6 Аудитын дүнд үндэслэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтолцооны дараах загварыг судалж, шийдвэрлэхийг санал болгож байна. Үүнд:

Бүдүүвч №3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах санал болгож буй бүтэц



Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг хангалттай зохион байгуулж ирээгүй нь гэмт хэргийн гаралт буурахгүй байх эрсдэлийг үүсгэж байна

1.7 Төлөвлөсөн үйл ажиллагаанд эзлэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээний хувийн жин бага байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг сулруулах эрсдэлтэй байна.

1.8 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дурдсан 3 байгууллагаас 2015-2017 онд төлөвлөсөн нийт 232 арга хэмжээний 29 буюу 12.5 хувь нь ГХУСТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад, 76 буюу 32.7 хувь нь иргэд, олон нийтэд сургалт, сурталчилгаа хүргэхэд, 54.8 хувь нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд тус тус чиглэгдсэн байна. Үүнийг хүснэгт №3-аар харуулбал,



Хүснэгт №3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээр төлөвлөсөн ажил /2015-2017/

Байгууллага	Он	Төлөвлөгдсөн нийт ажлын тоо	Эрх зүйн баримт бичиг боловсруулах чиглэлээр	Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээний хүрээнд	Орон нутгийн салбар зөвлөлийн хүрээнд	Иргэний нийгмийн байгууллагын хүрээнд	Сургалт, сурталчилгаа	Үүнээс ГХУСТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад нийцэх ажлын тоо
ХЗДХЯ	2015	32	2	6	4	3	15	3
	2016	10	1	-	-	-	9	1
ГХУСАЗЗ	2017	53	12	24	4	5	8	12
Байгууллага	Он	Төлөвлөгдсөн нийт ажлын тоо	Удирдлага зохион байгуулалт, судалгааны ажлын талаар	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажлын уялдааг хангах	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээг зохион байгуулах талаар	Иргэний нийгмийн байгууллагын хүрээнд	Сургалт, сурталчилгаа	Үүнээс ГХУСТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад нийцэх ажлын тоо
ЦЕГ	2015	45	9	9	8	5	10	4
	2016	44	16	7	9	5	7	2
	2017	48	13	26	-	-	9	7

Эх үүсвэр: ХЗДХЯ, ГХУСАЗЗ, ЦЕГ-ийн 2015-2017 оны ажлын төлөвлөгөө

1.9 Нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг цөөн төлөвлөж ирсэн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсөв, хүн хүчний нөөцийг үр ашиггүй зарцуулж, шалтгаан нөхцөлийг арилгахад чиглүүлэн зохион байгуулах ажлын цар хүрээ, далайц, тоо хэмжээг хумих хүчин зүйл болж байна.

1.10 Энэ нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг нэгдмэл байдлаар, бодитой судалж тогтоогоогүй, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг тодорхойлох ажил хангалтгүйгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжгүй болж, хөрөнгө, нөөцийг сургалт сурталчилгаа гэсэн ерөнхий, нийтлэг, шууд үр нөлөө багатай арга хэмжээнд чиглүүлж иржээ.

1.11 Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээний заримыг хэрэгжүүлэхдээ хугацаа алдсанаас төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал,

ХЗДХС-ын тушаалаар 2015-2017 онд төрийн болон ТББ-уудын төлөөллөөс бүрдсэн замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг 2 удаа байгуулагдсан боловч ямар нэгэн үндэслэлгүйгээр ХЗДХЯ-наас зөвхөн ЦЕГ-ын хуулийн хэлтсийн боловсруулсан төслийг үндэслэн дүрэм боловсруулахаар шийдвэрлэж, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

1.12 2015-2016 онд зохион байгуулагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтийг ашиглан “Радар шинжилгээ”¹⁰-ээр үзэхэд сүүлийн 10 жилийн гэмт хэргийн тоо, нас барсан хүний тоо, гэмтсэн хүний тоо, хохирлын хэмжээ, гэмт хэрэгт холбогдсон хүний тоо, 100.0 мянган хүнд ногдох гэмт хэргийн тооны дундаж үзүүлэлтүүдээс 2015-2016 оны үзүүлэлтүүд их байгаа нь өнөөг хүртэл хэрэгжүүлж, зохион байгуулагдсан арга хэмжээний үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.


¹⁰ Радарын график нь олон цэгийн өгөгдөлийг ижил цэгээс эхлэх тэнхлэгт харуулсан гурван буюу түүнээс олон тооны хувьсах хэмжигдэхүүний хоёр хэмжээст график хэлбэрээр үзүүлэх график арга юм.

Зураг №1. Үр дүнг хэмжих үзүүлэлтүүдээр байгуулсан радар дүрслэл

Хүснэгт №4 Үр дүнг хэмжих үзүүлэлтүүд

	Сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлт	2015 он	2016 он
Гэмт хэргийн тоо	23106	27757	27167
Нас барсан хүний тоо	1127	847	880
Гэмтсэн хүний тоо	9309	11287	11257
Хохирлын хэмжээ /тэрбум төгрөг/	87.1	144.3	162.9
Гэмт хэрэгт холбогдсон хүний тоо	20784.3	24857	23805
100000 хүнд ногдох гэмт хэргийн тоо	809.1	907.7	870.7

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын 2007-2016 оны статистик мэдээ



Цагдаагийн алба хаагчдын ажлын ачаалал их байгаагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж хязгаарлагдаж байна

1.13 Засгийн газрын 2011 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолоор 4000 иргэнд нэг хэсгийн байцаагч¹¹ ажиллахаар заасан боловч 2017 оны байдлаар дунджаар 8648 хүн амтай нэг хороонд 1 хэсгийн байцаагч буюу 2.2¹² дахин их ачаалалтай ажиллаж байна.

1.14 ХЗДХЯ Засгийн газрын дээрх тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй, цагдаагийн байгууллагын орон тоо 2011 оноос, замын цагдаагийн орон тоо 2008 оноос хойш нэмэгдээгүй бөгөөд улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалж орон тоо нэмэгдэх боломжгүй үед зохион байгуулалтын болон техник, технологиор шийдэх асуудлыг шийдвэрлээгүй өнөөг хүрсэн байна. Үүнээс болж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн цагдаагийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд төсөв, хөрөнгийг зохицуулсан хуулийн харилцан нийцэлгүй заалтууд сөргөөр нөлөөлж байна

1.15 Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2-т¹³ заасны дагуу аймаг, нийслэлийн ИТХ-аас улсын хэмжээнд 2017 онд нийт 587 ОНЦ-гийн орон тоо батлагдсан боловч бодит гүйцэтгэлээр 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 388 ОНЦ ажиллаж байна.


1.16 Зарим аймаг, тухайлбал Завхан, Сэлэнгэ, Төв, Увс аймгууд ОНЦ огт ажиллуулаагүй бол Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудад орон тоо 188-аар дутуу байна. Эдгээр аймгуудын 2015-2017 оны хагас жилд бүртгэгдсэн гэмт хэргийн сар бүрийн дундаж тоог ОНЦ огт ажиллаагүй, дутуу ажиллуулсан, ажиллаж байгаа аймгуудаар харьцуулан харуулбал,

¹¹ Цагдаагийн албаны тухай хуулиар даалгасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр тодорхой нутаг дэвсгэрийн нэгжийг хариуцан Цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилогдсон цагдаагийн офицерыг хэсгийн байцаагч гэнэ. Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, үр дүнт танилцуулах гэх мэт 15 чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

¹² ЦЕГ-ын 2015-2017 оны үйл ажиллагааны тайлан мэдээллийг ашиглан тооцоолсон аудитын багийн дүгнэлт.

¹³ Аймаг, нийслэлийн Засаг даргаас Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагатай зөвшилцөн гаргасан саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олон нийтийн цагдаагийн тоог жил бүр тогтооно.

Зураг №2: ОНЦ ажиллаагүй болон ажиллаж байгаа аймгуудын харьцуулалт



Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын 2015, 2016, 2017 оны хагас жилийн статистик мэдээ

1.17 2015, 2016 онд “Хөршийн хяналт” хөтөлбөр, 2017 оны 8 дугаар сарын байдлаар “Эргүүл” хөтөлбөрийн хүрээнд “Оюутан цагдаа”, “School Police” гэсэн арга хэмжээнүүдийг тус тус амжилттай хэрэгжүүлж дараах үр дүнд хүрсэн байна. Тухайлбал,

- Иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Хөршийн хяналт” хөтөлбөрийн хүрээнд 2020 он хүртэл 6 зорилт, 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2015, 2016 онуудад 3 зорилт, 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлжээ. Үр дүнд хөршийн хяналтын нэгдсэн сүлжээг бий болгож 2 217 иргэнийг бүртгэж, үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлжээ.
- Гадаадын иргэд, жуулчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор давхардсан тоогоор 238 иргэнийг оюутан цагдаагаар ажиллуулжээ. Хөтөлбөрийн үр дүнд гадаадын иргэд гэмт хэргээс өртсөн байдал 2016 оныг 2015 онтой харьцуулахад 45 нэгж буюу 23.3 хувиар, 2017 оны эхний 8 сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24 нэгж буюу 28.5 хувиар буурчээ. Мөн 2015 онд 13695, 2016 онд 18540, 2017 онд 8782 гадаадын иргэнд зөвлөгөө өгсөн байна.
- Сургуулийн орчинд “School Police” арга хэмжээг зохион байгуулж эцэг эхчүүдэд мэдлэг олгож, сургууль цуглах, тарах цагаар байнгын эргүүл ажилласнаар сурагчдыг гэмт хэргээс өртөх, замын хөдөлгөөнд аюулгүй оролцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.18 Мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.8¹⁴-д ОНЦ-тай холбоотой зардлыг ГХУСТХ-д заасны дагуу санхүүжүүлнэ гэсэн боловч ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.3.2¹⁵-т гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас зөвхөн ОНЦ-гийн урамшууллыг санхүүжүүлэхээр зааж, ОНЦ хувцас, тусгай хэрэгслээр хангагдах, сургалтад хамрагдахад зориулсан төсвийн зохицуулалтыг орхигдуулсан байна.

1.19 Иймд гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажилд ОНЦ-гийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд дээрх хуулиудын орхигдуулсан заалтыг шийдвэрлэх, тэдний гүйцэтгэх ажил, үүрэгт гэмт үйлдэл, зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлоход чиглүүлэх шаардлагатай байна.

1.20 Үүнээс гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “иргэдийг нийтийн эргүүлд гаргах”, 12.1.2-д “иргэдийг хэв журмын урамшуулалтай эргүүл, жижүүрээр томилох” гэсэн заалтуудыг Дорноговь, Дорнод, Дундговь, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай аймгууд хэрэгжүүлээгүй байна.

¹⁴ Олон нийтийн цагдаагийн таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгсэл, урамшил, сургалт явуулахтай холбогдсон зардлыг тухайн шатны Засаг дарга гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлнэ.

¹⁵ Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах.

Хууль зүй, дотоод хэргийн яам гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ТББ-уудтай байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээг дүгнэдэггүйгээс үр дүнг үнэлэх боломжгүй байна

1.21 ХЗДХЯ 2015-2016 онд Засгийн газрын тухай хуулийн 19¹⁶ дүгээр зүйлд заасны дагуу 25 ТББ-тай гэрээ байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил гүйцэтгүүлэхдээ сонгон шалгаруулалт явуулаагүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийг зөрчиж иржээ.

1.22 Түүнчлэн тус яамны төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Ж.Баярцэцэг нь 2016 оны А/13 дугаар тушаалаар сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг батлан төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг шалгаруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 131.8 сая төгрөгийг зарцуулсан нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13.6¹⁷, Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2¹⁸ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

1.23 ГХУСТХ-ийн 5.1.5-д заасны дагуу иргэдэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулсан гэх боловч зарим ТББ нь гэрээний үүргийн дагуу хийсэн ажлын тайланг ирүүлээгүй, гэрээнд тусгагдсан ажлыг бодитойгоор гүйцэтгэсэн эсэх нь тодорхойгүй байна.

1.24 ХЗДХЯ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ТББ-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг дүгнэдэггүйгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын үр дүнг үнэлэх боломжгүй байна. Тухайлбал:

- ✚ Монголын хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэнтэй “Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн болон ял эдлүүлэхийг хойшлуулсан хорих байгууллагаас суллагдсан хүүхдүүдийг нийгэмшүүлэх” 5.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Бие даасан хөгжил ТББ-тай “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд Нарантуул худалдааны төвд хүнд хөдөлмөр эрхэлж буй 6-16 насны хүүхдүүдэд хөдөлмөрийн мөлжлөгийн чиглэлээр сургалт явуулж, эрүүл мэндийн үзлэгт хамруулах 9.7 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Монголын хүүхдийн эрхийн үндэсний төвтэй “Бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хэрхэн хамгаалах талаар сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн багш нарт сургалт хийх” 9.6 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Цагаан соён ТББ-тай “Мансууралгүй ирээдүй” сэдэвт сургалтуудыг зохион байгуулах 10.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй байна.
- ✚ Баялаг бүтээгч Монгол хүн ТББ-тай “Хүүхдийн эрх хамгаалалтад бидний оролцоо сургалт хийх” 7.4 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Олон нийтийн харилцааны эвсэл ТББ-тай “Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах” 15.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Үлэмж үзэхүй судлалын төв ТББ-тай “Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах” 12.3 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Тойм-Инк ХХК-тай “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд шинээр боловсруулж буй хуулийн төсөл, батлагдсан хуулиудын талаар мэдээллийг олон нийтэд түгээх, таниулах ажил гүйцэтгэх гэрээ” 18.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Ижил гараа ТББ-тай “Хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийг иргэдэд таниулан сурталчлах чиглэлээр хамтран ажиллах” 7.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Хууль сахигч ТББ-тай “Хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийг иргэдэд таниулан сурталчлах чиглэлээр хамтран ажиллах” 6.5 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- ✚ Номун студи ТББ-тай “Авилгын эсрэг “Шудрага ёсыг шударгаар тогтоох нь” баримтат уран сайхны кино хийх” 49.5 сая сая төгрөгийн гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулалт явуулаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлан гаргуулаагүй, гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй байна.

¹⁶ Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх.

¹⁷ Сангийн хөрөнгийг сангийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн дараах зориулалтаар зарцуулна.

¹⁸ Сангийн зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 3.1.2 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг шалгаруулах.

1.25 Мөн зарим ТББ-ын үүсгэн байгуулагдсан болон ХЗДХЯ-тай гэрээ байгуулсан огноо нь ойролцоо, сонгон шалгаруулалтгүйгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн зэргээс үзэхэд зөвхөн санхүүжилт авах зорилгоор эдгээр ТББ-ууд байгуулагдсан, үүний цаана ашиг сонирхлын зөрчил үүссэн байх эрсдэлтэй байгаа тул хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд,

Хүснэгт №5 үүсгэн байгуулагдсан болон ХЗДХЯ-тай гэрээ байгуулсан огноо нь ойролцоо ТББ-ууд

№	ТББ-ын нэр	Регистрийн дугаар	Удирдах зөвлөлийн дарга	Үүсгэн байгуулагдсан огноо	ХЗДХЯ-тай гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн /мянган.төгрөг/
1	“Ижил гараа” ТББ	8153361	Н.Мөнхзул	2014.10.20	2015.07.24	7,000.0
2	“Хууль сахигч” ТББ	8153353	Э.Золжаргал	2014.10.20	2015.07.24	9,500.0
3	“Эрх зүйн сэтгүүлчдийн клуб” ТББ	8231214	Д.Цогзолмаа	2017.01.07	2017.01.24	16,000.0
4	“Эрх зүйн индэр” ТББ	8231036	Д.Цогзолмаа	2017.01.04	2017.01.24	12,000.0
5	“Нийгмийн эмч”	8231362	Д.Цогзолмаа	2017.01.05	2017.01.24	12,000.0
6	“Мэдээллийн гүүр”	8236526	Х.Гантуул	2017.02.20	2017.03.27	1,000.0
7	“Танин мэдэхүйн бахархал төв” ТББ	8232806	Ц.Галбадрах	2017.02.20	2017.05.20	4,000.0
Нийт						61,500.0

Эх сурвалж: Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны 8/9904 дүгээр албан бичиг, ХЗДХЯ-ны 2017 оны 1-4/4321 дугаар албан бичиг

1.26 Түүнчлэн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд зарим ТББ-ууд улсын бүртгэлд бүртгэлгүй, үйл ажиллагаа явуулдаг эсэх нь тодорхойгүй, НББ-ын тухай хууль, ТББ-ын тухай хуульд заасны дагуу санхүүгийн тайлангаа гаргадаггүй зөрчлүүд аудитын явцад илэрсэн учир хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал,

- Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлгүй: “Номун студи”, “Үлэмж үзэхүй судлалын төв”, “Ухаарахуй” ТББ-ууд,
- Сангийн яамны санхүүгийн тайлангийн системд бүртгэлгүй: “Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг”, “Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг”, “Хэл, хил, мал гурав”, “Үлэмж үзэхүй судлалын төв”, “Монголын хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн”, “Монголын чөлөөт нийгмийн ажилтны төв”, “Мэдээллийн гүүр”, “Цаглашгүй мэдлэг”, “Ухаарахуй” ТББ-ууд.

Төсвийг зориулалт бусаар зарцуулснаас шалтгаалж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжээгүй байна

1.27 Нийслэлийн ИТХ бүрдүүлсэн төсвийг зориулалт бусаар зарцуулснаас шалтгаалан гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах үйл ажиллагааны санхүүжилт хүрэлцэхгүйд хүрч, улмаар төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжээгүй байна.

- Хулгайн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалсны үндсэн дээр хулгайлсан эд зүйлсийг цааш нь борлуулдаг сүлжээ, худалдан авдаг зах зээл байгаа нь тус гэмт хэрэг буурахгүй байх шалтгаан болж байгааг тодорхойлсны дагуу барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулж буй газрууд /ломбард/-ын барьцаалсан эд зүйлсийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг Нийслэлийн Цагдаагийн газрын 2017 оны төлөвлөгөөнд тусгасан боловч төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан хэрэгжээгүй ажээ¹⁹. Гэтэл нийслэлийн ИТХ 2016-2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулагдсан төсвөөс 435.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- ЦЕГ-ын мөрдөн байцаах албанаас мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ХХААХҮЯ-ны мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран алдагдсан болон олдсон малын тухай мэдээллийг иргэдээс үнэ төлбөргүй авах Малчин лавлах-109 дугаарын утсыг 2016 онд ажиллуулснаар орон нутаг, нийслэлийн 4 дүүрэгт нийт 8846 мал алдагдсаны 5086 нь лавлах утасны мэдээллийн дагуу эргэж олдсон сайн үр дүнтэй арга хэрэгжиж байсан бол 2017 онд хөрөнгө санхүүжилтгүй шалтгаанаар энэ ажил зогсонги байдалд оржээ.
- ЦЕГ-ын замын цагдаагийн алба 2017 онд нийт 630 мянган хэрэг зөрчил илрүүлж, 18.6 тэрбум төгрөгөөр торгох шийтгэл ногдуулснаас нийслэлийн төсөвт 12.6 тэрбум төгрөг төвлөрүүлсний

¹⁹ Цагдаагийн 2017 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний 2.2.2 дахь заалтын биелэлт.



зөвхөн 1.7 хувь буюу 225.7 сая төгрөгийг ЗЦА-нд нийслэлийн ИТХ, Засаг даргын шийдвэрээр олгосон байна. Энэ санхүүжилтээр албанд шаардлагатай зарим багаж, техник хэрэгслийг авах, шинэчлэхэд зарцуулсан бөгөөд санхүүжилтийн хүрэлцээгүй байдлын улмаас “Хүүхдийг зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх”, “Зам тээврийн осол гаралтыг бууруулах”, “Олон нийт хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах” стратегийн зорилтын хүрээнд төлөвлөсөн нийт 61 төрлийн ажил үйлчилгээний 72 хувийг дотоод нөөц бололцоо, иргэд, ААН-ийн нийгмийн хариуцлага, ГХУСТХ-иар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байна.

+ ХЗДХЯ нь ЦЕГ-ын сургалтын төвтэй Улаанбаатар хотын хэмжээнд 3100 цагдаагийн албан хаагчийг шинэчилсэн хуулиудын сургалтад хамруулах зорилгоор гэрээ байгуусан боловч гэрээнд заасан сургалтыг явуулаагүй 18.6 сая төгрөгийг сургалтын төвийн засварын ажилд зориулсан байна.

**Бүлэг 2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хамрах хүрээ, арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байна**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг өргөжүүлж арга хэлбэрийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна

2.1 2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийг 20 үндсэн ангилалд хамааруулан авч үзэж байгаа бөгөөд 2016 оны байдлаар эдгээр гэмт хэргийн улмаас 27.7 мянган хүн хохирч, 162.9 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирсан байна.

2.2 Захиргааны хариуцлагын тухай хуулиар захиргааны хариуцлагыг 52 үндсэн ангилалд хамааруулж ирсэн бөгөөд 2015 онд 1,423.1 мянга, 2016 онд 1,038.1 мянга, 2017 оны эхний хагаст 739.3 мянган /өмнөх оны мөн үеэс 54.2 хувиар өссөн/ зөрчил бүртгэгджээ. Зөвхөн 2016 онд нийт 1,001.4 мянган иргэн, 107 албан тушаалтан, 1167 аж ахуйн нэгж зөрчил гаргасан байна.

2.3 2017 оны 07 дугаар сарын 01-нээс мөрдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулиар зөрчлийг тодорхойлсон нэгдсэн ойлголттой болсон хэдий ч эдгээр зөрчлийн тоо бүртгэл, статистик мэдээлэл боловсруулалт, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг судлах, дүн шинжилгээ хийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах бүтэц, тогтолцоо бүрдээгүй байна.

2.4 Зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл бүхий нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлох ажил нэгдмэл байдлаар хийгдэхгүй байна. Тухайлбал,

- ✚ Замд хэтэрхий ойр баригдаж байгаа барилга, хашаа, хамгаалалт
- ✚ Замын хөдөлгөөний аюулгүй байдалд эрсдэл үүсгэх нөхцөл байдлууд, тухайлбал гэрлэн дохионы буруу зохицуулалт, тэмдэг, тэмдэглээний буруу байрлал, гарц, уулзварын аюулгүй байдал гэх мэт;
- ✚ Гэрэлтүүлэг болон хяналтын камер, хангалттай байдал, эвдрэл;
- ✚ Хамгаалалтгүй болон ил задгай байршсан өндөр хүчдэл цахилгааны шугам, холболт;
- ✚ Хөдөлгөөнд оролцогчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдлууд, тухайлбал, элдэв нүх, саад, хальтиргаа гэх мэт.

2.5 Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг өргөжүүлэн, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг нэгтгэж авч үзэх, нийтийн хэв журмыг хамгаалах газрын бие бүрэлдэхүүн болон ОНЦ-гийн чиг үүрэгт нэмж тусгах замаар нутаг, дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил үүсэх, гарах эрсдэл бүхий нөхцөл байдлыг урьдчилан үнэлж байх, тус үнэлгээнд үндэслэн шаардлагатай арга хэмжээг захиргааны шугамаар заавал шийдвэрлэдэг байх улс орны онцлогт нийцүүлсэн эрх зүйн зохицуулалтыг судалж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн туршлагауудыг дэмжих бодлого, эрх зүйн зохицуулалтгүйгээс хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна

2.6 Манай улсад ашиглагдаж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аргууд нь хүн амын суурьшил ихтэй нутаг дэвсгэрт хүртээмж багатай, иргэд олон нийтийн оролцоо, санаачилга, хууль, цагдаагийн байгууллагын хүн хүч, санхүүгийн нөөц бололцоог шаардсан, гол төлөв эргүүл жижүүр, байнгын хяналтаар нийтийн хэв журмыг сахиулах хэлбэртэй байгаа нь үр ашиг багатай, өнөөгийн нөхцөл, шаардлагад тохиромжгүй байна.

2.7 Хуулиар тодорхойлсон дээрх аргуудыг өнөөгийн нөхцөл байдалд хэрхэн ашиглаж байгаа талаар үнэлбэл,

Хүснэгт №6. ГХУСТХ-д заасан аргуудын үнэлгээ

Хуулийн зүйл, заалт	ГХУСТХ-д заасан аргууд	Одоо мөрдөгдөж буй байдал	Үнэлгээ
12 дугаар зүйл /12.1-12.5/	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах	ОНЦ, “Оюутан цагдаа”, “School Police” зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж байна. ГХУСТХ болон Цагдаагийн албаны тухай хуулийн харилцан зөрүүтэй зохицуулалтаас шалтгаалан ОНЦ нар хувцас, тусгай хэрэгслээр хангагдах, сургалтад	Олон нийтийн цагдаа ажиллаж байгаа аймгийн гэмт хэргийн бүртгэл ОНЦ ажиллуулаагүй байгаа аймгынхаас харьцангуй бага байх хандлагатай байна. /Зураг №2/ Иймд ОНЦ-г ажиллуулах хууль, эрх зүйн орчинг өөрчлөн цаашид үр дүнтэй ажиллуулах шаардлагатай байна.



		хамрагдахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байна.	“Оюутан цагдаа”, “School Police” хөтөлбөрүүд үр дүнгээ өгсөн сайн ажил болсон учир цаашид үргэлжлүүлэн ажиллуулах шаардлагатай.
13 дугаар зүйл /13.1-13.4/	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах	ГХУСТХ-ийн 13.2-т зааснаар 2017 онд ГХУСАЗЗ-ийн ажлын албанаас санаачлан Нийслэлийн ГХУСАЗСЗ-тэй хамтран орон сууцны гадна орчин, гэр хорооллын гудамж, талбайг камержуулах болзолт уралдааныг зохион байгуулж, идэвхтэй оролцсон ААН-ийг шагнасан байна. ГХУСТХ-ийн 13.1-д зааснаар иргэдийг урамшуулах хэлбэрээр олгох зардлыг тусган тайлагнаагүй байсан тул уг арга дутуу хэрэгжилттэй байна	Хуулиар тодорхойлогдсон энэхүү аргын шалгуур үзүүлэлт нь тодорхой бус, иргэдийг шударгаар тэгш урамшуулах тогтолцоог бүрдүүлээгүй байна. Иймд энэ аргыг илүү тодорхой болгож сайжруулах шаардлагатай байна.
14 дүгээр зүйл /14.1-14.6/	Гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах	Орон нутагт Баянхонгор, Сэлэнгэ Төв, Хөвсгөл, Хэнтий, Архангай, Өмнөговь аймгаас бусад аймаг энэхүү аргыг ашиглаагүй байна.	Мэдээллийн нууцыг хамгаалах, мэдээллийг үнэлэх асуудал тодорхой бусаас шалтгаалж хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг үнэлж холбогдох өөрчлөлтийг хийж шинэчлэх шаардлагатай байна.
15 дугаар зүйл /15.1-15.11/	Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох.	2015-2017 онд хорих ял эдлээд хугацаанаас өмнө суллагдсан 1475 хүнд дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтоосон бөгөөд сүүлийн 3 жилд 18 хүн давтан хэрэг үйлдсэн гэсэн мэдээлэл судалгаа гарсан. 2016 оныг өмнөх онтой харьцуулахад захиргааны хяналтад байхдаа дахин гэмт хэрэг үйлдсэн хүний тоо өссөн.	Захиргааны хяналтад байгаа иргэдийн 0.01 хувь нь дахин гэмт хэрэг үйлдсэнээс үзэхэд энэхүү арга үр дүнтэй байна.

Эх сурвалж: Аудитын дүнд үндэслэсэн мэдээлэл

2.8 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэлбэрүүдийг дэлхий нийтийн даяаршил, хүн амын өсөлт, амьдрах, оршин тогтнох хэлбэр түүний сөрөг нөлөөлөл, зарим өөрчлөлт, хандлагатай нийцүүлэн шинэчилж, техник технологийн ололт амжилтыг ашиглан, үр ашигтай хэлбэрээр хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хүснэгт №7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын туршилагыг хэрэгжүүлж байгаа байдал

Нэршил	Зорилго	Үр дүн	Манай улсад ашиглаж байгаа байдал
Хөршийн холбоо	Хулгайлах гэмт хэргээс ялангуяа орон байрны хулгайн гэмт хэргээс сэргийлэхэд чиглэгдсэн төдийгүй халаасны хулгай, машины хулгай зэргээс урьдчилан сэргийлэх	Иргэдийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлснээр өртөг багатайгаар үр дүн хүрэх боломжтой бөгөөд үр дүнтэй болгохын тулд иргэн бүр үүргээ ухамсарлах, ёс зүйтэй байх шаардлагатай	“Хөршийн хяналт” хөтөлбөрийн хүрээнд “Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-т уг аргыг баталж хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.
Хяналтын камер, гэрэлтүүлэг	Танхайрах, хүний биед хохирол учруулах, дээрэмдэх гэмт хэргээс сэргийлэх	Шөнө, оройн цагаар гэрэлтүүлгийг нэмэгдүүлж орчин тойрон, иргэдийн аюулгүй байдлыг хангаж, илрүүлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ. Анхаарах асуудал нь хэрэглээний	“Хяналтын камер”-ын системийг ашиглан гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаа газрыг тодорхойлж, хэрэг, зөрчилтэй тэмцэх оновчтой аргыг төлөвлөн хэрэгжүүлснээр гаралтыг бууруулах зорилгоор үйл ажиллагаандаа ашиглаж байна. Гэхдээ хяналтын камерыг ГХУСТХ-д



		зардлыг оновчтой сайн тооцоолох хэрэгтэй.	нэмэлт өөрчлөлт оруулж хуульчлан баталж, санхүүжилтийг шийдэх хэрэгтэй байна.
Эрсдэлтэй цэгүүдийг хяналтад авах /Hot spots policing/	Хаягжилтын системд тулгуурласан гэмт хэргийн зураглал нь гэмт хэргийн хамгийн их гардаг голомт цэгүүдийг тогтоож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратеги боловсруулахад чухал ач холбогдолтой.	Гэмт хэргийн газар зүйн мэдээллийг боловсруулж, урьдчилан сэргийлэх стратегийг боловсруулах, хаягжилтийн системийг нэвтрүүлж, газар зүйн мэдээллийн тусламжтайгаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой болно.	Гэмт хэрэг хамгийн их гардаг цэгүүдийг тогтоож, мэдээллийн сангийн менежментийн системийг боловсруулан, тоон мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулах ажил хийгдэж байна. Гэхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлогоор дэмжих шаардлагатай байна.

2.9 Иймд хууль, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж буй шинэ дэвшилтэт аргуудыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд нэмэлтээр оруулан батлуулах, ашиглаж байгаа арга, хэлбэрүүдээс нөхцөл байдалд нийцүүлэн төрийн бодлогоор дэмжин эрх зүйн зохицуулалт хийх, хөрөнгө санхүүжилтийн боломжит эх үүсвэрээр хангах замаар хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

Замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэх шаардлагатай байна

2.10 2015 оны 9 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д УИХ “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого”-ыг тодорхойлох гэж заасан боловч өнөөг хүртэл бодлого тодорхойлогдоогүй байна.

2.11 Улсын хэмжээнд 2017 оны байдлаар бүртгэлтэй 760 гаруй мянган автомашин, жолоодох эрхийн үнэмлэхтэй 1.2 сая иргэн, замын хөдөлгөөнийг зохицуулах 975 цагдаагийн албан хаагчтай бөгөөд нэг албан хаагчид 1500 автомашин ногдож байгаа нь батлагдсан жишгээс 10-12.5 дахин их байна. Жилд дунджаар 2000 зам тээврийн осол бүртгэгдэж, ослын улмаас 550 хүн нас барж, 1200 хүн гэмтэж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 10.0 орчим тэрбум төгрөгийн хохирол учирч байна.

2.12 Цагдаагийн албан хаагчийн орон тооны хүрэлцээгүй, орон нутгийн замд тавих хяналт хангалтгүйгээс хурд хэтрүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалах бүс, малгай, хүүхдийн суудал зэргийг хэрэглэхгүйгээр замын хөдөлгөөнд оролцдог нь зам тээврийн ослын гол шалтгаан болж байна.

2.13 Мөн замын хөдөлгөөний дүрэмд 2004 оноос хойш өөрчлөлт оруулаагүй бөгөөд өнөөгийн нөхцөл байдалтай нийцүүлэн шинэчлэх шаардлага байна. Тухайлбал,

- Дүрмийн 28.1-а-д “Тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон тооноос олон хүн тээвэрлэхийг хориглоно” гэсэн заалтын тайлбарт: Тээврийн хэрэгслээр зорчигчийн тоонд 12 нас хүрээгүй хүүхдийг тооцохгүй бөгөөд харин уг тээврийн хэрэгслийн бодит жин нь бүх жингээс хэтрэхгүй байвал зохино” гэж заасныг өөрчлөх,
- Тээврийн хэрэгслүүд хажуугийн болон хоорондын зай барьж яваагүйгээс шүргэлцэж бага хэмжээний хохирол үүссэн зөрчлийг цагдаагийн байгууллагад дуудлага өгч шалгуулах асуудал удааширдгаас замын түгжрэл ихээр үүсч улмаар давхар ослууд гарах эрсдэлийг бууруулах талаар заалт нэмэх,
- Тээврийн хэрэгслийн тоо жил бүр өсөж байгаа ч энэ нь зам тээврийн осол гарах гол шалтгаан биш бөгөөд хөдөлгөөнд оролцож буй авто машины тоог насжилт, техникийн байдлаас хамааруулан бууруулах оновчтой арга хэмжээ авах,
- Техникийн үзүүлэлт хангалтгүй авто машинуудыг хил гаалиар оруулах татварын хувь хэмжээг төрөөс оновчтой бодлогоор зохицуулахгүй байгаа нь зам тээврийн осол, улмаар байгаль орчны эсрэг гэмт хэрэг үүсэх нөхцөлийг бүрдүүлж байгаа зэрэгт анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэлбэр оновчгүй байгаагаас гэмт хэргийн гаралт буурахгүй байна.

2.14 “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-иар хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх оновчтой

хэлбэр нь хамтарсан багийг²⁰ ажиллуулах гэж үзэн хуульчлан баталсан боловч төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сулаас шалтгаалж тухайн багийн хэрхэн ажиллах, санхүүжүүлэх журмыг өнөөг хүртэл батлаагүй байна.

2.15 Хамтарсан баг ажиллуулах нь далд орчинд үйлдэгдэж буй хэрэг зөрчлүүдийг илрүүлэх, таслан зогсоох оновчтой арга хэлбэр болж чадаагүй нь удаа дараалан бүртгэгдэж буй хүчирхийлэл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргүүдийн гаралт буурахгүй байгаагаас харагдаж байна.

2.16 Түүнчлэн боловсролын яам “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлд²¹ заасны дагуу бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, стандартад зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох агуулгыг тусган боловсруулж хүргэх асуудлыг хэрэгжүүлж эхлээгүй байна.

Гэмт хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлж байгаа эрсдэлтэй цэгүүдийг хяналтад авч, цэгцлэх шаардлагатай байна

2.17 Тусгай зөвшөөрөлтэй нэрийн дор стандартын шаардлага хангаагүй зочид болон дэн буудлын эмх замбараагүй үйл ажиллагааг цэгцлэх талаар төрөөс холбогдох арга хэмжээг авахгүйгээр 20 орчим жил болж байгаа нь гэмт хэрэг гарах орчин нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал,

✚ СХД-ийн 12, 13, 14, 15, 16 дугаар хороодод байршилтай 8 зочид буудал 14 дэн буудлуудын зарим нь 2000 оны эхээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн ч өнөөг хүртэл архидан согтууралт, биеэ үнэлэлт зэрэг хууль бус үйл ажиллагааг явуулсаар байна.

2.18 Дэн буудлын чиглэлээр үйлчилгээ эрхэлж орлого олдог иргэд, ААН-ийн үйл ажиллагааг төрөөс бодлогоор зохицуулж, стандарт шаардлага хангасан зочид буудлын зэрэглэлд шилжүүлэх, тэдний ажлын байрыг хадгалахаас гадна хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох давхар арга хэмжээг нутаг дэвсгэр хариуцсан мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагын хяналтан дор хамтран хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна

2.19 2015 онд ХЗЯ /хуучин нэрээр/ ХСИС-ийн бүтэц, дүрэм, хичээлийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээг төлөвлөсөн ч үүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр төлөвлөгөө тусгаагүй ба одоо энэ чиглэлээр хуулийн салбарт дагнан ажиллах боловсон хүчингүй байна.

2.20 Архи согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгчид, донтогсдыг эмчлэх, хүүхэд, залууст хор хөнөөлийг таниулах, хорт зуршлаас салгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, боловсон хүчин бэлтгэх ажил хангалтгүй байна. Тухайлбал,

✚ Архины шалтгаант болон сэтгэц зан үйлийн эмгэгтэй өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээг ЭМЯ-тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч энэ чиглэлээр үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд болон хувь хүнийг сонгон шалгаруулах журмыг ХЗДХС-ийн тушаалаар батлуулсан ч хэрэгжилтийг хангаж ажилласан талаар,

✚ Хүүхэд, оюутан залуусыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист донтохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилго бүхий байгууллага, тусгай дугаарын утсыг нээж ажиллуулсан талаар тайлан мэдээлэл алга байна.

2.21 Иймд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах, иргэдэд үйлчлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэхэд хуулиар тодорхойлсон арга хэлбэр үр дүн багатай байгаад дүн шинжилгээ хийж өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн

²⁰ Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална.

²¹ Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох агуулгыг бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах.

Үндснээр шинэчлэл хийж ажиллахад Засгийн газар, салбарын яам, агентлаг, зөвлөлийн түвшинд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ажлын албаны үйл ажиллагаа тогтворгүй, байнгын бус, үйл ажиллагааг зохистой төлөвлөж ирээгүй нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байх шалтгаан болж байна

2.22 Монгол улсад ГХУСА33-ийн ажлын албаны үйл ажиллагаа тогтмол бус байсан бөгөөд Хууль зүйн сайдын 2012 оны А112 дугаар тушаалаар ажлын албаны чиг үүргийг ХЗЯ-ны /хуучнаар/ Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хамруулсан байна. Ерөнхийлөгчийн 2016 оны 134 дүгээр зарлигаар ГХУСА33-ийн бүрэлдэхүүнийг 33 гишүүнтэйгээр шинэчлэн баталсан байна.

2.23 Гэвч орон тооны бус энэхүү зөвлөлийн бүрэлдэхүүнд яамдуудын дэд сайд, ТНБД, агентлагийн дарга нар байдаг учир ирц бүрддэггүй шалтгаанаар журамд заасан хугацаанд²² хуралддаггүй, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

2.24 ХЗЯ /хуучнаар/ 2015-2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг урт, дунд хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх стратеги байхгүй, жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа хэвшмэл, нэгэн хэвийн тодорхой арга хэмжээнүүдийг жил дараалан төлөвлөж ирсний зэрэгцээ зарим төлөвлөсөн ажлыг үндэслэлгүй шалтгаанаар тасалдуулж иржээ. Тухайлбал:

- ✚ Хууль Зүйн Яамнаас /одоогийн ХЗДХЯ/ 2015 онд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг шинэчлэн боловсруулахаар төлөвлөсөн боловч үндэсний хөтөлбөрийг батлагдсаны дараа хуулийн төслийг боловсруулж эхлэнэ гэсэн шалтгаанаар хэрэгжээгүй,
 - ✚ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдан 1 удаа хуралдсанаас өөр тодорхой ажил хийгээгүй,
 - ✚ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг хэрэгжүүлээгүй гэж мэт.
- Дараах ажуудыг 2015 болон 2016 онд давтан төлөвлөсөн байна. Үүнд:
- ✚ Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг ЗГХЭГ-т хүргүүлэх,
 - ✚ Хар, тамхи сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,
 - ✚ Хар тамхи мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах,
 - ✚ Галт зэвсэг түүнтэй адилтгах хэрэгслийг импортлох, худалдах зэрэгтэй холбоотой дүрэм журам боловсруулах.

2.25 ГХУСА33 нь журмаар улиралд 1-ээс доошгүй хуралдах ёстой бөгөөд жилд 1 удаа хуралдах зэргээр үйл ажиллагаа нь тогтмол бусаас төлөвлөсөн ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

Төлөвлөсөн арга хэмжээ	Тасалдсан шалтгаан, тайлбар
Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт хууль, эрх зүйн хичээлийг тусгайлан заах, гэмт хэрэг түүний хор уршиг, урьдчилан сэргийлэх дадал хэвшлийг олгох чиглэлээр сургалтын хөтөлбөрийг боловсруулах;	ХЗДХС бөгөөд ГХУСА33-ийн даргын 1-1/2664 тоот бичгээр БСШУСЯ-нд чиглэл хүргүүлсэн боловч тодорхой ажил хийгдээгүй байна.
Хорих ял эдлээд суллагдсан иргэдийг нийгэмшүүлэх тогтолцоог Монгол улсад бий болгох, онол арга зүйн суурь судалгааны төслийг боловсруулах;	Арга хэмжээг ХНХЯ, ШШГЕГ, ХСИС-тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба онол арга зүйн суурь судалгааны ажлын төслийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулсан ч тогтолцоог бий болгоогүй байна.
Замын чанар хөдөлгөөний аюулгүй байдлын стандартыг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэн батлуулах	ЗТЯ, ЦЕГ-тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч энэ ажил хэрэгжээгүй байна.
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр ХЗДХЯ, УЕПГ, Дээд шүүх, МХЕГ, ОБЕГ-с санаачлан хэрэгжүүлэх хамтын ажиллагааг зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах	Тус арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Зөвлөлийн даргын 1-1/2664 тоот албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагаат хяналт шалгалт хийгдээгүй байна.

²²ГХУСА33-ийн ажиллах журмын 1.4-т “Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан мөн. Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн олонхи нь хуралдаанд оролцож байгаа бол түүнийг хүчинтэйд тооцно.” гэж заажээ.



2.26 ГХУСА33 хуулиар үүрэг хүлээсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд оролцогч байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулаагүй, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцох шалгуур, хүрэх түвшингийн үзүүлэлтийг тодорхойлоогүйгээс үр дүн тодорхой бус байна. Тухайлбал:

- ✚ Аудитын явцад шаардлагатай мэдээллийг цуглуулах зорилгоор хууль сахиулах зарим төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудаас авсан санал асуулгад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын алба хууль сахиулах бусад байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар хангасан, бие даасан тодорхой хариулт ирүүлээгүй,
- ✚ Мөн орон нутаг дахь салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалтгүй ГХУСА33-ийн ажлын албанаас мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаагаар хангаж ажиллаагүй,
- ✚ ХЗДХС-ын тушаалаар 2017 онд байгуулсан 9 дэд зөвлөл журмын дагуу сайдад ажлаа тайлагнаагүй байна.

2.27 Иймд ГХУСА33-ийн өнөөгийн чиг үүргийг орон тооны бүтцээр дамжуулан, тасралтгүй, тогтвортой, байнгын болгох замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, тогтолцоог шинэчлэх шаардлагатай байна.

2.28 Ингэснээр гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, тэдгээрийг арилгахад чиглэсэн нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг бодитой төлөвлөж, хэрэгжүүлэх, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнг үнэлэх үйл ажиллагааг сайжруулах боломжтой.

Засгийн газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийх шаардлагатай байна

2.29 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан хэрэгжүүлэх байгууллага нь хуулийн дагуу Засгийн газар бөгөөд улсын хэмжээнд зохион байгуулах ерөнхий болон тусгай арга хэмжээний хөтөлбөр төлөвлөгөөг батлахаар тусгасан боловч хуулийн салбарт баримтлах гол эрх зүйн баримт бичгүүд батлагдаагүй байна. Тухайлбал,

- ✚ “Төрөөс нийтийн хэв журмыг хамгаалах талаар баримтлах бодлого”,
- ✚ “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого”,
- ✚ “Төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар баримтлах бодлого” тодорхойлох,
- ✚ Монгол улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.4.4, 5.4.6, 5.4.8, 4,9 дэх заалтуудыг хэрэгжүүлэх ажлууд удааширсан байдалтай байна.



Бүлэг 3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах ажлыг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсвийг хуульд заасны дагуу батлаагүйгээс зорилтод үр дүнд хүрэх боломжийг хязгаарласан байна

3.1 ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан ч улсын хэмжээнд 2015-2017 онд Нийслэл болон Говь-Алтай, Төв, Өвөрхангайгаас бусад аймаг /81.8 хувь/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулах төсвийг хуульд заасан хэмжээнд төлөвлөж, батлаагүй байна.

Хүснэгт №8. Аймаг, нийслэлийн ИТХ-аас баталсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсөв /сая төгрөг/

№	Аймаг, нийслэлийн нэр	Хүү, торгуулийн орлого 2014 он	40 хувь	2015 онд төлөвлөсөн	Хүү, торгуулийн орлого 2015 он	40 хувь	2016 онд төлөвлөсөн	Хүү, торгуулийн орлого 2016 он	40 хувь	2017 онд төлөвлөсөн
1	Архангай	0	-	56.20	255.4	102.2	67.0	334.2	133.7	63.4
2	Баян-Өлгий		-	20.0	105.0	42.0	20.0	252.2	100.9	20.0
3	Баянхонгор		-	60.0	258.5	103.4	80.0	335.3	134.1	80.0
4	Булган		-	46.2	162.2	64.9	56.8	191.2	76.5	46.9
5	Говь-Алтай	63.5	25.4	49.3	87.7	35.1	57.3	139.8	55.9	51.6
6	Дорноговь		-	70.4	189.6	75.8	59.4	373.4	149.4	58.8
7	Дорнод	138.6	55.4	46.6	195.9	78.4	68.5	324.2	129.7	67.7
8	Дундговь		-	31.0	101.4	40.6	36.0	161.6	64.7	30.7
9	Завхан	58.9	23.6	27.5	156.7	62.7	27.5	171.9	68.8	29.5
10	Өвөрхангай		-	83.80	112.9	45.2	78.5	179.1	71.6	89.9
11	Өмнөговь		-	27.60	154.0	61.6	49.7	225.3	90.1	72.6
12	Сүхбаатар		-	16.7	169.2	67.7	24.5	211.7	84.7	15.3
13	Сэлэнгэ	341.3	136.5	104.2	533.2	213.3	54.3	735.0	294.0	74.4
14	Төв	141.2	56.5	76.4	197.4	79.0	93.8	214.4	85.8	73.7
15	Увс		-	56.7	125.6	50.2	59.5	211.6	84.6	29.8
16	Ховд	176.3	70.5	61.8	176.3	70.5	59.2	247.9	99.2	68.1
17	Хөвсгөл	115.3	46.1	46.1	147.2	58.9	56.1	221.9	88.7	54.4
18	Хэнтий	393.5	157.4	40.0	343.5	137.4	71.0	353.9	141.6	48.0
19	Дархан-Уул		-	100.0	337.0	134.8	75.6	574.2	229.7	110.3
20	Орхон	251.7	100.7	253.7	399.4	159.8	251.2	538.2	215.2	146.6
21	Говьсүмбэр	55.9	22.4	20.3	123.4	49.4	28.7	211.9	84.8	47.5
22	Нийслэл	8100.0	3,240.0	3240.0	13100.0	5,240.0	5240.0	13100.0	5240.0	5240.0
Аймаг, нийслэлийн дүн		9836.2	3934.5	4534.5	17431.5	6972.6	6614.6	19308.9	7723.7	6519.2

Эх үүсвэр: Аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллагын “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангаас

3.2 Дээрх нөхцөл байдал нь аймаг, нийслэлийн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвөө хуульд нийцүүлэн бодитой төлөвлөдөггүй, Сангийн яам ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт нийцүүлэн төсвийг хянадаггүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг шалтгаалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах төсөв дутагдаж, зорилтод үр дүнд хүрэх боломжийг хязгаарласан байна.

3.3 Мөн ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2²³ дахь заалтын дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг сум, дүүргийн Засаг даргад гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилаагүй нь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэслэл бүрдээгүй, хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал,

²³ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Засаг даргад гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилж зарцуулна.

- Архангай, Баян-Өлгий, Дундговь, Завхан, Булган, Дорноговь, Дундговь, Ховд, Дархан-Уул аймаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг сумдуудад хуваарилаагүй,
- Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Орхон, Говьсүмбэр аймаг дээрх зардлыг гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзалгүйгээр бүх сумдад тэгшитгэн хуваарилсан,
- Сүхбаатар, Сэлэнгэ, Төв аймгийн сумдуудын ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаа өөрсдөө баталсан.

3.4 Аймаг, нийслэлийн ИТХ гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлийн тооцоо судалгаанд үндэслэн тухайн тайлант онд зохион байгуулах ажлын чиглэл тус бүрт зарцуулагдах зардлыг тооцдоггүй, сумдын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулдаггүй нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, үр нөлөөг бууруулах шалтгаан болж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөв, санхүүжилттэй холбоотой заалтуудыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна

3.5 ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1²⁴ дэх хэсэгт заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг 40 хувиар тооцоход оруулсан хүү, торгуулийн орлогын хэмжээнээс хамааран жил бүр харилцан адилгүй төсөв батлагдахаар байгаа нь Төсвийн тухай хуулийн дор дурдсан заалттай зөрчилдөж байна. Тухайлбал,

- 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэсэн зарчимтай,
- 6 дугаар зүйлийн 6.4.7-д “Төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээ, ... тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх” гэж заасантай,
- 14 дүгээр зүйлийн 14.2.2-т заасан “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхтэй.”
- 22 дугаар зүйлийн 22.1-д заасан “Төсвийг тогтоосон ангиллын дагуу /хөтөлбөрөөр/ төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана” гэж заасантай,
- 22 дугаар зүйлийн 22.6.4- д заасан “Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.6 Хууль зүйн сайд /хуучнаар/, Сангийн сайд нарын 1998 оны 88/152 тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулах зардлын төлөвлөлт, гүйлгээний баримтанд гарын үсэг зурах тухай болон хөрөнгийн үлдэгдлийг дараагийн жилд зарцуулах эсэхийг шийдвэрлэх заалтууд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5²⁵, Сангийн сайдын 2017 оны 216 тушаалаар батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.1²⁶ дэх заалттай нийцэхгүй байна.

3.7 Иймд 1997 онд батлагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон 1998 онд батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ыг Төсвийн болон Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

²⁴ Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

²⁵ Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

²⁶ Төсвийн шууд захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчид, төсвийн ерөнхийлөн захирагч нь Сангийн яаманд төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг энэ журамд заасны дагуу тооцож, холбогдох бусад мэдээллийн хамт хүргүүлнэ.

ХЗДХЯ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, батлаагүй, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж байгаагүйгээс 2015-2017 онд нийт зардлын 39.0 хувийг зориулалт бусаар зарцуулжээ

3.8 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд санхүүжилтийг зарцуулах чиглэлүүдийг ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.3.1²⁷, 19.3.2²⁸, 19.3.3²⁹, 19.3.4³⁰, 19.3.5³¹, 19.3.6³² дахь заалтуудад тусгаж өгсөн боловч улсын хэмжээнд 2015-2017 онд нийт зардлын 14.5 хувь буюу 2,449.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулж Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5³³, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.4³⁴ дэх заалтыг тус тус зөрчсөн байна. /Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2015-2017 онд зарцуулсан зардлын судалгааг хавсаргав. Хавсралт №1,2,3/

3.9 Үүний дотор ХЗДХЯ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас хуулийн төсөл боловсруулах, гадаад томилолт, хүлээн авалт, хурал зөвлөгөөн, орчуулга, яамны бусад үйл ажиллагаа, хуульд заагаагүй урамшуулал зэргийг санхүүжүүлж, 2015-2017 онд нийт зардлын 39.0 хувь буюу 1,124.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Зориулалт бус зарцуулалтыг зардлын төрлөөр харуулбал,

Хүснэгт №9. Зориулалт бус зардлууд /сая төгрөгөөр/

№	Зардлын төрөл	2015	2016	2017.VI	Нийт (3+4+5)
1	2	3	4	5	6
1	Сургалт ³⁵	19.5	83.4	443.0	545.9
2	Гадаад томилолт	47.6	27.6	84.0	159.2
3	Хөрөнгө оруулалт		113.4		113.4
4	Хурал зөвлөгөөн	3.0	64.6	61.2	128.8
5	Хуульд заагаагүй урамшуулал		1.6		1.6
6	Сурталчилгаа		9.0	13.4	22.4
7	Хуулийн төсөл боловсруулах	18.3	18.0	30.5	66.8
8	Зочин хүлээн авах	11.0	55.3	1.5	67.8
9	Орчуулга	1.1	10.3		11.3
10	Бусад		8.2	0.6	8.8
	Нийт	100.4	391.3	633.1	1,124.8

Эх сурвалж: ХЗДХЯ-ны СХО-ын газраас авсан мэдээллийг боловсруулав.

3.10 Мөн аймаг, нийслэлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2015-2017 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн зардлын 9.4 хувь буюу 1,324.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал,

- Увс аймгийн ИТХ 2016 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Х.Баянмөнх аваргын дүрс бүхий 50 ширхэг метал сувинерт 2.2 сая төгрөг,
- Сэлэнгэ аймаг ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн даргыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас цалинжуулж 2015-2017 онд 23.5 сая, зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 1.5 сая төгрөг
- Сүхбаатар аймагт ИТХ-ын аппаратын үйл ажиллагааны зардалд 28.6 сая төгрөг,
- Төв аймгийн ИТХ-ын 2015 оны 11 дүгээр хуралдааны хоолны зардалд 2.7 сая төгрөг,
- Хөвсгөл аймагт 2015 онд Мөрөн хотын 55 жилийн ойн 155 ширхэг хүндэт тэмдгээр шагнахад 600.0 мянган төгрөг
- Ховд аймгийн Мянгаат сумын Засаг даргын Тамгын газарт адууг омгоор баталгаажуулах зардалд 3.2 сая төгрөг, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан ахмад настан Н.Дамбад нэмэгдэл тэтгэвэр 6.9 сая төгрөг, шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан хүмүүсийн нөхөн олговорт 7.2 сая төгрөг гэх мэт

3.11 Дээрх нөхцөл байдал нь хуулийн төсөл боловсруулах, хууль сурталчлах зардал Сангийн яамнаас баталсан эдийн засгийн ангилалд байдаггүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсвийг Төсвийн тухай хуульд заасны дагуу үйл ажиллагаа, арга хэмжээ тус бүрээр нарийвчлан

²⁷ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх.

²⁸ Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах.

²⁹ Энэ хуулийн 13 дугаар зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах.

³⁰ Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх.

³¹ Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх.

³² Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх.

³³ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна.

³⁴ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

³⁵ ХЗДХЯ-ны үйл ажиллагааны зардалд сургалтад зориулсан зардал тусгагдсан байхад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас хүний нөөцийн чадавхийг сайжруулах чиглэлийн сургалтуудад зарцуулсан зардал.

төлөвлөж, хянадаггүй, ГХУСА33-өөр хэлэлцүүлдэггүйгээс шалтгаалж, батлагдсан санхүүжилтийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн байна

3.12 ХЗДХЯ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор бусад байгууллагуудаар гүйцэтгүүлсэн ажлын гэрээний үүргийн хэрэгжилт, анхан шатны баримтыг аудитын явцад түүвэрчлэн шалгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ.

3.13 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ТББ-уудтай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөрийн тайлан, санхүүгийн баримт ХЗДХЯ-нд байхгүй, ажил хийгдсэн эсэх тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1³⁶, 13.5³⁷, 13.7³⁸ дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2³⁹, 20 дугаар зүйлийн 20.2⁴⁰ дахь хэсэг болон гэрээний зарим заалтуудыг зөрчсөн байна. Тухайлбал,

- ✚ Монголын хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэнтэй “Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн болон ял эдлүүлэхийг хойшлуулсан хорих байгууллагаас суллагдсан хүүхдүүдийг нийгэмшүүлэх” 5.0 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Бие даасан хөгжил ТББ-тай “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд Нарантуул худалдааны төвд хүнд хөдөлмөр эрхэлж буй 6-16 насны хүүхдүүдэд хөдөлмөрийн мөлжлөгийн чиглэлээр сургалт явуулж, эрүүл мэндийн үзлэгт хамруулах 9.7 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Монголын хүүхдийн эрхийн үндэсний төвтэй “Бага насны хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хэрхэн хамгаалах талаар сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн багш нарт сургалт хийх” 9.6 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Цагаан соён ТББ-тай “Мансууралгүй ирээдүй” сэдэвт сургалтуудыг зохион байгуулах 10.0 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Баялаг бүтээгч Монгол хүн ТББ-тай “Хүүхдийн эрх хамгаалалтад бидний оролцоо сургалт хийх” 7.4 сая төгрөгийн гэрээ;
- ✚ ЦЕГ-ын сургалтын төв “Улаанбаатар хотын хэмжээнд 3100 цагдаагийн албан хаагчийг хуулийн сургалтанд хамруулах 18.6 сая төгрөгийн гэрээ, сургалт зохион байгуулаагүй засвар тохижилтод зарцуулсан;
- ✚ Олон нийтийн харилцааны эвсэл ТББ-тай “Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах” 15.0 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Үлэмж үзэхүй судлалын төв ТББ-тай “Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах” 12.3 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Тойм-Инк ХХК-тай “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд шинээр боловсруулж буй хуулийн төсөл, батлагдсан хуулиудын талаар мэдээллийг олон нийтэд түгээх, таниулах ажил гүйцэтгэх гэрээ” 18.0 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Ижил гараа ТББ-тай “Хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийг иргэдэд таниулан сурталчлах чиглэлээр хамтран ажиллах” 7.0 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Хууль сахигч ТББ-тай “Хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийг иргэдэд таниулан сурталчлах чиглэлээр хамтран ажиллах” 6.5 сая төгрөгийн гэрээ;
- ✚ Номун студи ТББ-тай “Авилгын эсрэг “Шудрага ёсыг шударгаар тогтоох нь” баримтат уран сайхны кино хийх” 49.5 сая сая төгрөгийн гэрээг байгуулахдаа тус тус санхүүгийн анхан шатны баримтгүй гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүйгээр санхүүжилт олгосон байна.

3.14 Зарим ТББ-тай байгуулсан гэрээнд “Гүйцэтгэгч тал гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд олгосон санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх..., захиалагч гэрээг дүгнэсний үндсэн дээр үлдэгдэл санхүүжилтийг олгох...” гэж заасан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй байхад олгосон санхүүжилтийг буцааж төвлөрүүлээгүй, гэрээг дүгнэхгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна. Тухайлбал,

³⁶ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

³⁷ Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.

³⁸ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

³⁹ Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах.

⁴⁰ Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоон дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна.

- + “Аминчхан яриа” ТББ-тай 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан №54 гэрээний 3 дугаар зүйлийн 3.3-т “Захиалагч гэрээг дүгнэсний үндсэн дээр үлдээгдэл 50 хувийн санхүүжилтийг олгох эсэхийг шийдвэрлэнэ” гэж заасан боловч гэрээг дүгнэлгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон,
- + “Монголын чөлөөт нийгмийн ажилтны төв” ТББ-тай 2016 оны 06 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан 52 тоот гэрээний 6 дугаар зүйлийн 6.2-т “Гүйцэтгэгч тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол захиалагч тал гэрээг цуцлан олгосон санхүүжилтийг буцаан төлүүлнэ” гэж заасан боловч гүйцэтгэгч тал гэрээний үүргээ биелүүлээгүй бөгөөд олгосон санхүүжилтийг буцаан төвлөрүүлээгүй байна.

3.15 Эдгээр зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргахгүй байх, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах талаар албан шаардлага хүргүүлсэн.

3.16 Мөн ХЗДХЯ хууль сурталчлах зорилгоор хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай гэрээ хийсэн боловч яамны үйл ажиллагаа болон сайдын ажлыг сурталчлан, мэдээлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төсөвлөсөн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Тухайлбал,

- + “Эдимүүн” ХХК /www.zaluu.com/-той 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан №114 гэрээгээр “Архины хор нөлөөг таниулах, архидагчид согтуурахтай тэмцэх, цахим сургалт сурталчилгаа хийх чиглэлээр хамтран ажиллах” гэсэн боловч “Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийн нээлт боллоо”, “Хууль зүй, дотоод хэргийн салбарт 3 генерал мэндэллээ”, “Сайдын зөвлөлийн хуралдаан боллоо” гэсэн сэдэвтэй нийтлэлийг;
- + “Монголын үнэн сонин”-той 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан №106 тоот гэрээний зорилго “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдэвт цуврал нийтлэл бэлтгэх” боловч “ХЗДХ-ийн сайд тангараг өргөх ёслолд оролцлоо”, “ШШГЕГ-ын албан хаагчдад орон сууцны түлхүүр гардуулав”, “ОХУ-ын Дотоод хэргийн сайд Монголд айлчилна” гэсэн сэдэвтэй нийтлэлийг;
- + “Медиа холдинг” ХХК /ТВ-9 телевиз/-тай 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан №95 гэрээний зорилго “Мансууруулах бодисын хууль бус эргэлт, түүний хор уршгийг нийгэмд сурталчлах” боловч “Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийн нээлт боллоо”, “ЦЕГ-ын даргад тэргүүн комиссар цол гардуулав” гэсэн сэдэвтэй нийтлэлийг;
- + “Аэ энд Жааг” ХХК /ТВ-25/-тай 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан №107 гэрээний зорилго “Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр батлагдсан хууль, эрх зүйг олон нийтэд танилцуулах чиглэлээр хамтран ажиллах” боловч “ХЗДХ-ийн сайд тангараг өргөх ёслолд оролцлоо”, “ШШГЕГ-ын албан хаагчдад орон сууцны түлхүүр гардуулав” гэсэн сэдэвтэй нийтлэлийг;
- + “Өдрийн сонин”-той 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан №16-110 гэрээний зорилго “Олон нийтэд эрхзүйн боловсрол олгох” боловч “Оросын холбооны улсад тэтгэлгээр суралцуулна”, “Ховд аймагт оношлогооны шинэ төв барина” гэсэн сэдэвтэй нийтлэлийг тус тус мэдээлжээ.

3.17 Иймд цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэлийг дүгнэж, үр дүнг тооцож байх нь зүйтэй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн цагдаагийн байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олгосон зарим санхүүжилтийг Төсвийн тухай хууль, ОНХС-ийн зааврыг зөрчиж олгосон байна

3.18 Аймаг, нийслэл, сум, дүүргийн цагдаагийн байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зориулж ОНХС, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Засаг даргын нөөц зэрэг эх үүсвэрүүдээс 2015-2017 онд 9,587.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь нийт зарцуулалтын 56.7 хувийг эзэлж байна.

3.19 Ийнхүү цагдаагийн байгууллагыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахад хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа нь сайн талтай боловч улс, орон нутгийн төсвийн санхүүжилт холилдсоноос зарим санхүүжилт Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.⁴¹ дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 7 дугаар бүлэг⁴²-ийг зөрчиж олгогдсон байна. Тухайлбал,

- + 2017 онд Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн барилгын дээврийн засварт 9.8 сая, хэлтсийн даргын томилолтын зардалд 2.0 сая төгрөгийг Нийслэлийн Засаг дарга олгож Төсвийн тухай хуулийг зөрчин орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагыг

⁴¹ Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.

⁴² Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэг.



санхүүжүүлсний дээр, Булган, Завхан, Орхон, Хэнтий зэрэг аймгууд 2015-2017 онд баяр наадмын үеэр хамгаалалтад ажилласан албан хаагчдын хоол, шатахуун, ОНЦ-ийн цалин, ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгал, сэлбэг хэрэгсэл, архины албадан эмчилгээнд иргэдийг явуулах зэрэг зардлыг ОНХС-гаас санхүүжүүлсэн нь тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан байна.

3.20 ЦЕГ-ын төсөвт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2016 онд 60.0 сая, 2017 онд 88.0 сая төгрөг батлагдсан бөгөөд түүнийг зарцуулах тодорхой төлөвлөгөөгүйгээс 2016 онд Цагдаагийн байгууллагын “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулахад 11.8 сая төгрөг, Ази-Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалтын үеэр шуурхай удирдлагын штаб ажиллуулахад 17.3 сая төгрөг зарцуулах зэргээр төсөвт байхгүй зардлуудыг санхүүжүүлэх эх үүсвэр болгон ашигласан байна.

3.21 Түүнчлэн ЦЕГ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ажилтнууд энэ чиглэлээр 2017 онд 88.0 сая төгрөг батлагдсаныг мэдээгүй, Санхүү, аж ахуйн алба нь зарцуулагдаагүй үлдэгдэл 85.4 сая төгрөгийг өр төлбөрт өгөхөөр тооцож байсныг залруулан ойлгуулсны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажил, зарцуулах төсвийн төлөвлөгөөг аудитын явцад гаргаж ирүүлсэн болно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн зарцуулалтад тавих хяналт сул байгаа нь батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна

3.22 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийн зарцуулалтад ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.5⁴³, “Монгол улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.4⁴⁴-т ИТХ, Төсвийн тухай хуульд заасан эрх бүхий этгээд, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хяналт тавьж ажиллахаар заажээ.

3.23 Гэвч энэхүү хяналтын тогтолцоо нь аймаг, нийслэлийн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвийг өөрөө баталж, зарцуулаад өөртөө хяналт тавих боломжийг өгснөөр ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байгаа тул төсвийг тухайн шатны Засаг дарга зарцуулж, ИТХ хяналт тавьдаг тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

3.25 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хөрөнгийн зарцуулалтын холбогдох материалыг шалгахад хяналтын зарчим зарим түвшинд алдагдсан байна. Тухайлбал,

- ✚ Дорнодоос бусад бүх аймаг, нийслэл, ХЗДХЯ-нд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавиагүй,
- ✚ ХЗДХЯ-ны Дотоод аудитын газраас 2015-2017 онд зөвхөн Архидан согтуурахтай тэмцэх сан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт хийсэн бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд бүхэлд нь хяналт хийгдээгүй,
- ✚ Аймаг, нийслэлийн ГХУСАЗСЗ-үүд сум, дүүрэгт хуваарилсан хөрөнгийн зарцуулалтын тайланг журамд заасны дагуу гаргуулан авч хянадаггүй зэргээс гадна ажлын уялдаа холбоо муу байна.

3.26 Ийнхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын зарцуулалтад тавих хяналт орхигдсоноос батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

⁴³ Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина.

⁴⁴ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайланг холбогдох байгууллагуудаас хагас, бүтэн жилээр гаргуулан авч, дүгнэлт хийх.

Холбогдох байгууллагын санал:



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2017.12.28 № 1-4/5001

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
С.ОЮУНБИЛЭГ ТАНАА**

“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заасны дагуу холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 15 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  Т.БАЯСГАЛАН

08 5496

C:\Doc\yam.A-5 2017

Хууль зүй, дотоод хэргийн яамны
төрийн нарийн бичгийн даргын
2017 оны 1-4 сүлдугаар албан
бичгийн хавсралт

Үндэсний аудитын газраас “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн” хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх хэсгийг үндэслэн дор дурдсан саналыг өгч байна. Үүнд:

Ерөнхий дүгнэлтийн хүрээнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.” гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төрөл, ерөнхий арга хэмжээ, тусгай арга хэмжээ, нэг бүрчилсэн арга хэмжээ гэсэн төрлүүдтэй байхаар, хуульчилж тус бүрийг дор дурдсанаар тодорхойлсон байна. Тухайлбал;

6.2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ гэнэ.

6.3. Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ гэнэ.

6.4. Тодорхой этгээд гэмт хэрэг үйлдэхээс болон давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ гэнэ.

Гэтэл хуульд ингэж тодорхой заасан байхад аудитын тайлангийн төсөлд хууль тогтоомжийн төсөл боловсруулах, түүнтэй холбогдон гарах бусад үйл ажиллагааг санхүүжүүлсэн асуудлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай холбогдолгүй мэтээр тайлбарласан байх тул **залруулах саналтай** байна.

2. Мөн Төсвийн тухай хуулийг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөнөөс эхлэн Төсвийн ерөнхийлөн захирагч нь хөтөлбөр, арга хэмжээ, үр дүнд суурилсан төсвийн төслийг боловсруулж эхэлсэн.

Хууль зүйн сайдын 2015-2016 оны төсвийн төслийг боловсруулахдаа Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 дугаар зорилт, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, Засгийн газрын 2012 оны “Хөтөлбөр батлах тухай” 252 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны “Хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 257 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны “Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай” 58 дугаар тогтоол, Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2015 он, 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхээр “Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт” хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг төлөвлөж, 2015 онд боловсруулах баримт бичгийн тоог 860, хянах эрх зүйн актын тоог 170, Сэтгэл зүйн анхан шатны сургалт болон мэргэжлийн сургалтад хамрагдан архины хамаарлаас гарах иргэдийн тоог 2500 байхаар, 2016 онд боловсруулах баримт бичгийн тоог 45, хянах эрх зүйн актын тоог 720, сэтгэл зүйн анхан шатны сургалт болон мэргэжлийн сургалтад хамрагдан архины хамаарлаас гарах иргэдийн тоог 2500 байхаар Хууль зүйн яам, Хууль зүй, дотоод

хэргийн яамны “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал”-ын ангилалд төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хуулийн хугацаанд хянуулан, шалгуур үзүүлэлтийн хамт Улсын Их Хурлаар 2015-2016 оны төсвийн хуулиар батлуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр төлөвлөн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 3 дугаар бүлгийг хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 дугаар зорилт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, “Монгол Улсын Эдийн Засаг Нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх “Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт” хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг төлөвлөж, боловсруулах баримт бичгийн тоо 45, хянах эрх зүйн актын тоо 720, сэтгэл зүйн анхан шатны сургалт болон мэргэжлийн сургалтад хамрагдан архины хамаарлаас гарах иргэдийн тоо 2500 байхаар төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хуулийн хугацаанд хянуулж Улсын Их Хурлаар 2017 оны төсвийн тухай хуулиар батлуулсан.

Дээрх баталсан төсвийг Сангийн сайдын 2014 оны “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал”-д иргэд хууль, эрх зүйн талаарх мэдлэг, мэдээлэл дутмагаас болж, гэмт хэргийн золиос болох нь түгээмэл бөгөөд цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтыг хангахад гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, тайлбарлан таниулах, энэ талаар сургалт зохион байгуулах, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг тэдэнд эзэмшүүлэх явдал чухал ач холбогдолтой гэдэг үүднээс хуулийн төсөл боловсруулах, сурталчлах, тандан судлах, гадаад хэлнээс орчуулга хийх, хууль боловсруулах ажлын хэсэг ажиллах, сургалт зохион байгуулах, олон улсын туршлага судлах, зөвлөх үйлчилгээ авах, сургалтын материал бэлтгэх, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллахаар, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн тушаалаар баталж, зарцуулах эрхийн саналыг тухай бүр албан бичгээр Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлж, гүйцэтгэлийг санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаж ирсэн болно.

Дээрх зардлаас хуулийн төсөл, боловсруулах ажлын хэсэгт доод талдаа 5-15 хүн цуглаж, 5-10 хоногоор вакум орчинд хуулийн төсөл боловсруулдаг. Сургагч багш бэлтгэх сургалтыг удаа дараа явуулсан бөгөөд нэг удаагийн сургалтад 150-200 хууль сахиулах алба хаагчдыг хамруулдаг тул хоол, цай, усны зардал тогтмол гардаг. Сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад зайлшгүй гардаг зардалд тарааж өгөх материал, багшийн хөлс, хоолны зардал мөн багтдаг.

3. Гадаад улс орны ижил төстэй хуулийн туршлагыг судлахад тэр бүр олон алба хаагчдыг хамруулах боломжгүй, зардал хүрэлцдэггүй тул гадны багшийг урьж аль болох олон сургагч багшийг бага зардлаар сургаж авах бодлогыг барьж ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2015 онд 482, 2016 онд 662 албан хаагчид шинээр батлагдсан хуулийг иргэдэд таниулан сурталчлах талаарх сургалт, 2017 онд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудын сургалтыг уг хуулиудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэх үүрэгтэй нийт 8463 төрийн албан хаагчдад зохион байгуулсан.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2015 онд 11 хууль батлагдаж, УИХ-д 13 хуулийн төсөл өргөн мэдүүлсэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 3 хуулийн төсөл 2016 онд 7 хууль батлагдаж, УИХ-д 11 хуулийн төсөл өргөн мэдүүлсэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 5 хуулийн төсөл хүргүүлсэн, 2017 оны эхний 6 сарын байдлаар 15 хууль баталсан байна. Үүнээс онцлон дурдвал Эрүү, Зөрчлийн багц хууль, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Дотоодын цэргийн тухай хууль зэрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулиуд батлагдсан ч хууль хэрэгжүүлэгчдийн зүгээс сургалт, сурталчилгаа хангалттай хийгдээгүй гэсэн үнэлэлтийг өгсөн.

Түүнээс гадна Галт зэвсгийн тухай хуулийн дагуу ажлын хэсэгт урамшуулал олгох асуудал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлж байгаа нэгэн хэлбэр болно. Гарал үүсэл нь тодорхойгүй галт зэвсгийг оруулахгүй байх үүрэг нь гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм.

Монгол Улсын 2015-2016 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт” хөтөлбөрийн хүрээнд 2015 онд боловсруулсан баримт бичгийн тоо 46, хянасан эрх зүйн актын тоо 716, сургалтад хамрагдаж, архины хамаарлаас гарсан хүний тоо 1245 байна.

Мөн 2016 онд хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан баримт бичгийн тоо 116, хянасан эрх зүйн актын тоо 1072, сэтгэл зүйн анхан шатны сургалт болон мэргэжлийн сургалтад хамрагдан архины хамаарлаас гарсан иргэдийн тоо 2651 гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

Түүнээс гадна дээрх зардлаас хил дамнансан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гадаад оронд томилолтоор ажиллах, гадны зочинг хүлээн авч гэрээ хэлэлцээр байгуулах, Ялтан шилжүүлэх гэрээнд гарын үсэг зурах зэрэг ажлыг зайлшгүй зохион байгуулах шаардлагатай байдаг.

Тус яамнаас 2016 оны хувьд тодорхой боловсон хүчин, материаллаг бааз, ажлын туршлага бүхий гүйцэтгэгчийг шалгаруулж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, бодитой хэрэгжихүйц төсөл, хөтөлбөрийг шалгаруулах зорилгоор Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016.04.14-ний А/13 дугаар тушаалаар “Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн **төслийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлт**” болон “Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүн”-ийг баталж ажилласан.

Засгийн газрын 2013 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрэм”-ийн 4.1.2, 4.1.3-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцах бөгөөд дараах байдлаар зохицуулна: - сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулахтай холбоотой бусад ажлыг зохицуулах; -сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах болон бусад үйл ажиллагаатай холбогдсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.” гэж заасны дагуу дээр дурдсан Комиссын бүрэлдэхүүнд Хууль зүйн яамны дарга бөгөөд Зөвлөлийн гишүүн болон Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Зөвлөлийн нарийн бичгийн дарга нар оролцож шалгаруулалтыг явуулсан. Уг Комиссын саналыг Хууль зүйн сайд бөгөөд Зөвлөлийн дарга болон Төрийн нарийн бичгийн дарга, Зөвлөлийн гишүүн гишүүдэд бичгээр танилцуулсан бөгөөд Комиссын саналд зарим өөрчлөлтийг оруулж, шийдвэрлэсэн.

Өөрөөр хэлбэл, 2016 онд архидан согтуурахтай тэмцэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх, төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг комисс явуулж, **саналаа**

танилцуулсан, түүнчлэн төсөл шалгаруулах, шийдвэрлэх үйл ажиллагаанд Зөвлөлийн гишүүдийн олонх буюу 4 гишүүн оролцсон тул Зөвлөлийн бүрэн эрхэд халдсан гэж үзэхээргүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл болон Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн хүрээнд Хяналт, шинжилгээ дотоод аудитын газар үйл ажиллагаагаа явуулдаг.

Дотоод аудитын дүрмийн 7.3 дахь хэсэгт “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ын дагуу үйл ажиллагаагаа явуулахаар заасан байдаг. “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ын 2010-д “Дотоод аудитын нэгж нь ...байгууллагын зорилго, зорилттой уялдуулан эрсдэлд суурилсан төлөвлөгөөг бэлтгэнэ”, мөн стандартын 2030-д “...батлагдсан төлөвлөгөөг биелүүлэхэд дотоод аудитын нөөцийг зохистой, хангалттай бөгөөд үр нөлөөтэй хуваарилах ёстой” гэж тус тус заасны дагуу тус нэгж нь харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээнд суурилан дотоод аудитын дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаа нь зөвхөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийн зарцуулалтад хяналт тавих биш холбогдох эрх зүйн актуудад дурдсанаар 7 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар заасан байдаг.

Тус нэгжээс 2015-2017 онд Архидан согтуурахтай тэмцэх сан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагаанд дотоод аудит хийн зөвлөмж өгч ажилласан.

Дээр дурдсан эрх зүйн акт болон олон стандартын дагуу эрсдэлд суурилан ажлаа төлөвлөж, нөөцийг хуваарилан үйл ажиллагаа явуулж байгаа ба Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд бүхэлд нь хяналт тавих нөөц, төлөвлөлт аудитын хамрах хугацааны хувьд байгаагүй болно.

Бүлэг 1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нэгдсэн бодлогогүй байгаа нь хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөг бууруулж, гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй байна гэсэн дүгнэлтийн хүрээнд:

1. Тайлангийн төслийн 1.20-д “төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил гүйцэтгүүлэхдээ сонгон шалгаруулалт явуулаагүй, ТБОНӨХБАУХА тухай хуулийг зөрчиж иржээ.” гэсэн нь 2015-2017 оны үйл ажиллагааг ерөнхийд нь дүгнэсэн байгаа тул Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба ажиллаж эхэлснээс хойшхи буюу 2016 оны дөрөвдүгээр улирал, 2017 оны ажлын талаар тайланд тусад нь тусгуулах саналтай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба нь 2017 оны 3 дугаар улиралд төрийн бус байгууллагуудын дунд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр сургалт, судалгаа, сурталчилгааны төслийн уралдаан зарласан. Нийт 58 төрийн бус байгууллагаас төсөл ирүүлснээс архидан согтуурахтай тэмцэх чиглэлийн 23 төслийг “Архидан согтуурахтай тэмцэх сан”-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 10 төрийн бус байгууллагыг шалгаруулж, санхүүжүүлсэн.

Бусад чиглэлээр 35 төрийн бус байгууллага төсөл ирүүлснээс 9 төрийн бус байгууллагыг шалгаруулж, хамтран ажиллаж байна.

Төсөл сонгон шалгаруулах зар болон сонгон шалгаруулалтын дүнгийн талаар тодорхой мэдээллийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл мэдээллийн цахим хуудас, нийгмийн сүлжээн дэх хуудсуудад тухай бүр тавьж, олон нийтэд хүргэж байсан болно.

Тайлангийн төслийн 1.21-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1.5 дахь заалтад заасны дагуу иргэдэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулсан гэх боловч зарим төрийн бус байгууллага нь гэрээний үүргийн дагуу хийсэн ажлын тайланг ирүүлээгүй, гэрээнд тусгагдсан ажлыг бодитойгоор нь гүйцэтгэсэн эсэх нь тодорхойгүй байна” гэсний хүрээнд:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 2016 оны 10 дугаар сард 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хийсэн гэрээ, гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн бөгөөд тус яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хандан гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийлгэсэн. Уг ажлын үр дүн болон ажлын албаны саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус бичгээр танилцуулсан.

Уг танилцуулгаар төрийн бус байгууллагатай хийсэн 10 гэрээний 120,377,050 төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгуулахаар, 4 гэрээний үлдэгдэл санхүүжилт 11,614,000 төгрөгийг дахин тайлан авч, хянасны дараа олгох эсэхийг шийдвэрлэхээр, 3 гэрээний үлдэгдэл санхүүжилт 5,700,000 төгрөгийг олгохгүй байхаар шийдвэрлэсэн саналыг хүргүүлсэн болно.

Бүлэг 2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хамрах хүрээ, арга хэлбэрийг шинэчлэх шаардлагын хүрээнд:

1. Тайлангийн төслийн 2.1-д “Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гэмт хэргийг 19 үндсэн ангилалд хамааруулан авч үзэж байгаа” гэсэн нь ямар ангиллыг хэлж байгаа тодорхойгүй байна. Хэрэв төрөлжүүлэн нэгтгэсэн бүлгийн талаар бол гэмт хэргийг нийт 20 бүлэгт төрөлжүүлэн нэгтгэсэн.

2. Тайлангийн төслийн 2.3-т Зөрчлийн тухай хуулиар зөрчлийг 197 үндсэн ангилалд ангилсан гэдэг нь мөн ялгаагүй бүлэг, эсхүл зүйлийг хэлж байгаа нь тодорхойгүй байна. Хэрэв төрөлжүүлэн нэгтгэсэн бүлгийн талаар бол Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын талаар бичсэнтэй адил “зөрчлийг нийт 12 бүлэгт төрөлжүүлэн нэгтгэсэн” гэсэн агуулгаар, эсхүл хоёр хуулийн зүйлийн тоогоор бичих нь зүйтэй байна. Тодруулбал, тайлангийн “үндсэн ангилал” гэдэгт юуг ойлгож байгаа нь тодорхойгүй байна.

3. Түүнчлэн тайлангийн төслийн 2.3-т “зөрчлийн тоо бүртгэл, статистик мэдээлэл боловсруулалт, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг судлах, дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах тогтолцоо бүрдээгүй” гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байгаагаас гадна ямар хугацааг хамруулж, ямар үндэслэлийг харгалзан үзэн ингэж дүгнэсэн нь тодорхойгүй байна.

Өөрөөр хэлбэл, 2017.07.01-ний өдрийг хүртэл Монгол Улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, статистик гаргах хууль, эрх зүйн орчин бүрдээгүй буюу 240 гаруй салбарын хуулиар зохицуулж байсан. Харин 2017.07.01-ний өдрөөс Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр Монгол Улс анх удаа зөрчлийн нэгдсэн системтэй болох хууль, эрх зүйн орчин бүрдсэнээс гадна Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хуулиар “зөрчлийн нэгдсэн тоо бүртгэл, статистик гаргах” чиг үүргийг прокурорын байгууллагад байхаар зохицуулсан байхад шүүх эрх мэдлийн байгууллага болох прокурорын чиг үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн чиг үүрэг мэтээр дүгнэсэн нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна.

4. Тайлангийн төслийн 2.3-т заасны хүрээнд, Засгийн газраас боловсруулж, өргөн мэдүүлсний дагуу 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурал Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Хууль батлагдахаас өмнө

хүчин төгөлдөр үйлчилж байсан 232 хууль дахь захиргааны зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тогтоосон хэм хэмжээ бүхий зохицуулалтыг хүчингүй болгож энэхүү хуульд төрөлжүүлэн нэгтгэснээр зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тогтоосон нэг хуультай болж чадсан.

Энэ нь практик болон онолын хувьд маш олон ач холбогдолтой бөгөөд тэдгээрээс хамгийн чухал үр дүн нь Үндэсний аудитын газрын тайлангийн 2.3 дахь хэсэгт дурдсанчлан зөрчлийн нэгдсэн тоо бүртгэлийг бий болгох, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах, тэдгээрт дүн шинжилгээ хийх, зөрчил, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг нэгдмэл бодлогоор хангах боломж нөхцөл бүрдсэнд байгаа юм.

Зөрчил, түүний шинж, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон Зөрчлийн тухай хуультай болсноор зөрчлийг тогтоож, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааг нэгдмэл зохицуулалттай болгох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн тогтолцоо, журам, аргачлалтай болох боломж бүрдсэн. Тийнхүү дээрхи харилцааг зохицуулсан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хариуцан боловсруулж, Засгийн газраас өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг Улсын Их Хурал 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоох бөгөөд Монгол Улсад зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх, зөрчилд шийтгэл оногдуулах үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахаар заасан. Энэхүү хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаар зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан зөрчлийн талаарх гомдол мэдээллийг болон зөрчлийн хэрэг үүсгэсэн тохиолдолд мөн хэргийг прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулахаар заасан.

Хуулийн дээрхи зохицуулалтын хүрээнд урьд өмнө байгууллага тус бүр дээр тусдаа бүртгэгддэг байсан, нэгдсэн бүртгэл, хяналтын тогтолцоо байхгүй байсан зөрчлүүд бүгд нэгдсэн бүртгэлтэй, хяналттай болсноор зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд чиглэсэн чухал алхам болсон.

Одоогоор шүүхийн болон цагдаагийн байгууллагад шийдвэрлэсэн зөрчлийн тоо бүртгэл хөтлөгдөж байна.

Тухайлбал, Цагдаагийн байгууллагад 2017 оны эхний 11 сарын байдлаар 1,204,950 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27.4 хувиар өссөн байгаа ба зөрчил гаргасан 1,171,070 иргэн, 44 албан тушаалтан, 775 хуулийн этгээдийг 36.2 тэрбум төгрөгөөр торгох, мөн 22692 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 10369 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт зөрчлийн 1,193,767 буюу 99.1 хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, 11,183 буюу 0.9 хувьд шүүгч шийтгэл ногдуулсан байна.

5. Тайлангийн төслийн 2.13-д заасны хүрээнд, Замын хөдөлгөөний дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг тус газраас дор дурдсан зарчмын шинжтэй шинэ зохицуулалтыг тусган боловсруулж, Ажлын хэсгийн гишүүдээс санал авч байна. Үүнд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор тус хуульд нийцүүлэн зарим хэсгийг шинээр өөрчлөн найрууллаа;
- Олон Улсын замын хөдөлгөөний Венийн конвенцид 2006 онд нэмэлт, өөрчлөлт орж, 2011 оноос хүчин төгөлдөр болсон тул уг нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгалаа;

- 2014 онд замын тэмдэг, тэмдэглэл, замын гэрлэн дохио, тэдгээрийг хэрэглэх Монгол Улсын стандарт өөрчлөгдөн батлагдсантай уялдуулан холбогдох өөрчлөлтийг тусгалаа;
- Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ялангуй хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой зохицуулалтыг шинээр тусгалаа;
- Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах чиглэлээр холбогдох өөрчлөлтийг тусгалаа;
- Замын хөдөлгөөний ачааллыг бууруулахын тулд болон 2016 онд унадаг дугуйн замын стандарт шинэчлэгдэн батлагдсантай уялдуулан унадаг дугуйн хөдөлгөөнийг зохицуулах тусгай бүлэг шинээр нэмж тусгалаа;
- Нийтийн тээврийн хэрэгслийн эгнээтэй холбоотой зохицуулалт шинээр тусгалаа;
- Сургууль орчмын бүсэд баримтлах дүрмийг шинээр нэмж тусгалаа;
- Тээврийн хэрэгслийн зорчигчийг хамгаалах хэрэгсэл-Олон улсын системийн стандарт ISO-г /хамгаалах малгай хүүхдийн хамгаалах суудал/ Монгол Улсын стандарт болгож баталсан. Энэ стандартын хэрэглээтэй холбоотой журмуудыг тодорхой тусгалаа.
- Төслийг гадаад улс орны замын хөдөлгөөний зохицуулалтын туршлага, замын хөдөлгөөний дүрмүүдийг /АНУ, Япон, БНСУ, ОХУ, Сингапур, Беларусь, Европын Холбооны Улсууд хүүхэдтэй холбоотой хамгаалах журмын талаар судлан, дэвшилтэт сайн зохицуулалтыг тусгалаа.
- Энэхүү төсөл нь анхаарал татсан, олон нийтийн нийтлэг, тун хэрэгцээт харилцааг зохицуулсан тул сайтар боловсруулах, олон улсын туршлага судлах зэрэг ажиллагаа ихтэй бөгөөд хоёр хүн сууж байгаад хийдэг ажил биш юм. Төслийг тус яам боловсруулж байгаа бөгөөд судалгааны ажлыг төрийн бус байгууллагаар хийлгэсэн болно. Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн төсөл боловсруулалтын шаардлага хангахгүй, хоорондоо зөрчилтэй байх тул дэвшилтэт зарим санааг авсан болно.

6. Тайлангийн төслийн 2.14-т заасны хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ыг 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн ХНХ-ийн сайдын А/173, ХЗДХ-ийн сайдын А/251, ЭМ-ийн сайдын А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан байна.

7. Тайлангийн төслийн 2.15-д заасны хүрээнд Цагдаагийн байгууллагын статистик бүртгэлээс үзэхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлснээс хойш гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдсэн нь хуулийн хэрэгжилт, тэр дундаа “хамтарсан баг” нь далд хэлбэрээр үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох оновчтой арга биш хэмээн дүгнэх нь хэт өнгөц байна. Тус хуулийн нэг чухал зорилт нь далд байгаа гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх бөгөөд хамтарсан багаас гадна төрийн алба хаагчид, иргэд мэдээлэх үүргийг хүлээсэн. Түүнчлэн өмнө нь гэмт хэрэг, зөрчилд тооцдоггүй байсан үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэгт тооцож, улмаар хохирогчийг хамгаалалтаар хангах, хэрэгцээтэй үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэхээр хуульчилсан

тул энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг мэдээлэл эрс нэмэгдэж байгаа билээ. Бусад орны туршлагаас үзэхэд мэдээлэх эрх, үүргийг хуульчилсан хууль хэрэгжиж эхэлсэн эхний 5 жил тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлт нэмэгдсэн байдаг. Энэ нь далд үйлдэгдсэн ч мэдээлэгдэхгүй, арга хэмжээ авагдахгүй байсан гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт нэмэгдэж байгаагаар холбоотой гэж үзэж болох юм.

Нөгөө талаар тус хуульд тусгагдсан анхан шатны нэгжийн мэргэжилтнүүд хамтран ажиллах буюу “Хамтарсан баг”-аар ажиллах арга зүй нь 2006 оноос эхлэн Монгол улсад туршигдсан бөгөөд үр дүнтэй болохыг төрийн болон ТББ, үйлчилгээ хүртээгсэд хүлээн зөвшөөрсөн аргачлал юм.

Жич: Улсын хэмжээнд 2017 оны эхний 11 сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1262 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 69 хэргээр буюу 5.2 хувиар буурсан бол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 4122 зөрчил бүртгэгдсэн байна. (2017 оны 2 дугаар сарын 1-нээс өмнөх гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн тусгай бүртгэл байгаагүй), Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хавсаргав.

8. Тайлангийн төслийн 2.17-д Тусгай зөвшөөрөлтэй нэрийн дор стандартын шаардлага хангаагүй зочид болон дэн буудлын эмх замбараагүй үйл ажиллагааг цэгцлэх талаар төрөөс холбогдох арга хэмжээг авахгүйгээр 20 орчим жил болж байгаа нь гэмт хэрэг гарах орчин нөхцөлийг бүрдүүлж байна гэжээ.

Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудлуудад энэ чиглэлийн үйл ажиллагааг хянах чиг үүрэг бүхий бусад төрийн байгууллагатай хамтарсан үзлэг шалгалтыг зохион байгуулж ирсэн. Тухайлбал: Монгол Улсын Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/325 дугаар тушаалаар Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Дүүргүүдийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс хамтран 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 20-ны хооронд хяналт, шалгалтын ажлыг зохион байгууллаа.

Шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 307 зочид буудал, 151 дэн буудал, нийт 458 газрын болон сүүлийн 5 жилд үйлдэгдсэн 936 гэмт хэргийн судалгааг гарган, ажлын хэсгийн хуралдааныг 3 удаа зохион байгуулж, шалгалт хийх хугацаа, чиглэл, ажиллах бүрэлдэхүүн, автомашин, шатахууныг шийдвэрлэж, дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн дарга нарт шалгалтад ажиллах алба хаагчдын ажиллах нөхцөлийг хангах, сахилга ёс зүй, албаны бэлэн байдал, аюулгүй байдлыг хангах, ажлын үр дүнг тогтмол тооцож, хяналт тавьж ажиллах талаар үүрэг, чиглэл өгсөн.

Зочид болон дэн буудалд үйлдэгдсэн гэмт хэргийн судалгаанаас үзэхэд бусдыг амиа хорлоход хүргэх 51, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 14, хүчиндэх 52, бусдын эд хөрөнгийг хулгайлах 324, бусдын биед гэмтэл учруулах 439, залилах 31, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 25 гэмт хэрэг байна.

Зочид буудал 124, дэн буудал 226, нийт 350 хамрагдсанаас зохих зөвшөөрөлгүйгээр үйлчилгээ эрхэлсэн зочид буудал 32, дэн буудал 93, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчсөн зочид буудал 8, дэн буудал 20, Онцгой байдлын албаны шаардлага, стандарт хангаагүй зочид буудал 39, дэн буудал 65, Мэргэжлийн хяналтын газрын стандарт, шаардлага хангахгүй зочид буудал 45, дэн буудал 66 нийт 368 газарт 12.700.000 төгрөгийн шийтгэл ногдуулж, 119 ширхэг спиртийн сул, 115 шил спиртийн өндөр агууламж бүхий шингэнийг хураан авч, мэдэгдэл, шаардлага 115-г өгч ажилласан.

Шалгалтад 458 газар хамрагдахаас үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 66, хаяг байршил тодорхойгүй 29, хаалттай байсан шалтгаанаар 13 нийт 108 газар хамрагдаагүй ба зөвшөөрөлгүй үйлчилгээ эрхэлсэн газруудын судалгааг дүүрэг тус бүрээр нь гарган нэгтгэсэн болно.

9. Тайлангийн төслийн 2.19.Хууль сахиулахын их сургуулийн үндсэн чиг үүрэг нь хууль сахиулагч бэлтгэдэг бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээлүүд нь хөтөлбөр тус бүрдээ тусгагдаад явдаг. Хуулийн салбарын бүх ажилтнууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өөр өөрийн ажлын байрны онцлогт тохирсон чиг үүрэг хүлээдэг, энэ чиг үүргээ гүйцэтгэх мэдлэг чадварыг Хууль сахиулахын их сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр бүрэн олгодог.

Ийм учраас Хууль сахиулахын их сургууль нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, хуулийн салбарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дагнан ажиллах боловсон хүчингүй гэж дүгнэх үндэслэлгүй юм. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжид зааснаар энэхүү арга хэмжээг нэг алба хаагч эсхүл нэг хэсэг хүн хариуцдаггүй бөгөөд олон хүний хамтын хөдөлмөр, олон чиг үүргийг гүйцэтгэж байж энэ урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явдаг. Эрх зүйн онолын хувьд ч ингэж үздэг.

10. Тайлангийн төслийн 2.25-д Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хуулиар үүрэг хүлээсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд оролцогч байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулаагүй, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцох шалгуур, хүрэх түвшингийн үзүүлэлтийг тодорхойлоогүйгээс үр дүн тодорхой бус байна. Тухайлбал, орон нутаг дахь салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалтгүй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаагаар хангаж ажилладаггүй гэжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба байгуулагдсанаас хойш орон нутгийн зохицуулах зөвлөлийг мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаагаар хангах чиглэлээр доорх ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Тухайлбал:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй ном /гарын авлага/-ыг ажлын албанаас эрхлэн гаргаж, аймаг, сум, дүүргийн зохицуулах зөвлөлд хүргүүлсэн. Орон нутаг дахь урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулах үүрэг бүхий албан тушаалтан ажилтнууд нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, нарийн бичгийн дарга нар буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар онолын болон хууль эрх зүйн мэдлэг дутмаг мэргэжлийн бус хүмүүс байдаг тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, онолын зарим суурь ойлголт, мэдэгдэхүүнийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэж болохуйцаар энгийн хэллэгээр тайлбарлаж оруулсан нь гарын авлагын давуу тал юм.
- Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг таниулах, уг ажлыг зохион байгуулах арга зүй, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх талаар сургалт семинарыг 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан.
- Аймаг нийслэлийн Хууль, эрх зүйн хэлтсийн дарга мэргэжилтнүүдэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй, ХЗДХЯ, ГХУСА33-өөс баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй ажлын талаар сургалт хийсэн.

- Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран зохион байгуулсан сургалтын үеэр нийт 330 сумын иргэдийн хурлын дарга нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүйн талаар сургалт орж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг таниулсан.
- Ажлын албанаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, Орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах, олон нийтийн дунд энэ талын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, уг ажилд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг татан оролцуулах, ажлыг үр дүнтэй зохион байгуулах талаар чиглэл бүхий албан бичиг, Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл аяныг орон нутагт зохион байгуулах ажлын удирдамжийг тус тус албан бичгээр хүргүүлж, ажлын гүйцэтгэлийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус танилцуулсан.
- Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” аяныг 06 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны хооронд зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан ажлыг Замын цагдаагийн алба болон орон нутгийн холбогдох байгууллагаас танилцуулгыг авч нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулсан.
- Орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг мэдлэг, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх ажлын хүрээнд Сэлэнгэ, Хэнтий, Сүхбаатар, Баянхонгор, Завхан, Архангай, Ховд, Дорнод аймагт тус тус албан томилолтоор ажиллаж, 2017 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс баримталж буй бодлого болон цахим гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодис, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох заавар, чиглэл өгч ажиллалаа.
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд 2017 оны 06 дугаар сарын 05,06-ны өдөр зохион байгуулсан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, байгууллага, иргэдийн оролцоог сайжруулья” сэдэвт зөвлөгөөг, Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран Ховд аймгийн Жаргалант суманд Хууль бус ан агнууртай тэмцэх нь баруун бүсийн сургалтыг зохион байгуулж, хууль сахиулах болон гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын 80 гаруй алба хаагчид оролцлоо. Мөн “Бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэхэд төрийн байгууллагуудын оролцоо” сэдэвт сургалтыг 11 дүгээр сарын 18-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд суманд тус тус зохион байгуулж, сум, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан албан хаагчид, эрүүл мэндийн нэгдлийн эмч нар, гэр бүл, хүүхэд, залуучуудтай ажилладаг нийгмийн ажилтнууд тус тус хамрагдсан.

11. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар 2017 онд байгуулагдсан 9 дэд зөвлөл журмын дагуу сайдад ажлаа тайлагнаагүй байна гэжээ.

Тус ажлын алба байгуулагдсанаас хойш тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, салбар дундын зохицуулалтыг хийж, хэрэгжиж буй ажлын үр дүнг дээшлүүлэх тулд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд 6 дэд зөвлөл байгуулан ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/27 тоот тушаалаар Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Дэд зөвлөлийг, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий дэд зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/173 тоот тушаалаар, Зам тээврийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Дэд зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/143 тоот тушаалаар, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий дэд зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/190 тоот тушаалаар, Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий Дэд зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/205 тоот тушаалаар буюу нийт 6 дэд зөвлөлийг байгуулан, 2017 оны ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа. Ажлын албанаас дэд зөвлөлүүдийн 2017 оны төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын тайланг Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулсан. Улирал тутам төлөвлөгөө, ажлын тайлангаа тус яамны ТЗУГ-т тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Бүлэг 3. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд хийсэн дүгнэлтийн хүрээнд:

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах:

Тус яамны 2017 оны төлөвлөгөөнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулахаар тусгасны дагуу холбогдох байгууллагын төлөөллөөс бүрдэх ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 05 сарын 26-ны өдрийн А/142 тоот тушаалаар ажлын хэсгийг байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлыг эхлүүлэн, гадаадын зарим улс орнууд (тухайлбал; Швед, Солонгос, Казахстан, Узбекистан, Беларусь)-ын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомж зэргийг судалж холбогдох материалыг бэлтгээд байна.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг олж тогтоох, арилгах чиглэлээр бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авах талаар одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулсан байдаг хэдий ч практикт хэрэгжилт хангалтгүй байдагтай холбогдуулан хэрэгжих боломжтой шинэ зохицуулалтын талаар дээр дурдсан судалгаануудад үндэслэн хуулийн төсөл, үзэл баримтлалд тусгах юм.

2.3. Улсын Их Хурлын Байнгын хорооны 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн “Шүүх хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай” 23 дугаар тогтоол, Монгол Улсын Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын 2015 оны 09 дугаар сарын 04-ны өдрийн А/194, 128 А/92 дугаартай “Шүүх, хууль сахиулах байгууллагуудын өгөгдөл солилцох дундын нэгдсэн сан бүрдүүлэх тухай” хамтарсан тушаал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Улсын ерөнхий прокурорын газрын тамгын газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ийн өдрийн А/261 А/171 А/67 А/32 дугаартай “Журам батлах тухай” хамтарсан тушаалын дагуу Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд мэдээллийн нэгдсэн сан бий болгохоор ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд 2018 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай болон Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиудын дагуу эрүүгийн хэрэг, зөрчлийн тоо мэдээг шинэчлэн гаргадаг болгох, шүүх, хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн статистик тоон мэдээг бодит цаг хугацаанд хурдан шуурхай гаргадаг тогтолцоог бий болгохоор зорьж байна. Төсөлд хамрагдсан байгууллагуудын дундын нэгдсэн мэдээллийн санг 2017 оны 03 дугаар сарын 24-ийн өдрийн А/261, А/171, А/67, А/32 дугаартай “Журам батлах тухай” хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан мэдээллийн жагсаалтын дагуу бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хоорондоо мэдээлэл солилцох програм хангамжийн нэгдсэн тогтолцоо бий болгосон. Ингэснээр цагдаагаас гомдол мэдээлэл прокурорт очих, буцаж цагдаагийн байгууллагад очих, прокуророос шүүхэд шилжүүлж байгаа эрүүгийн хэрэг, зөрчлийн хэрэг цахим хэлбэрээр шүүхэд шилжих, шүүхийн шийдвэр прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт цахим хэлбэрээр очдог мэдээллийн урсгал 2017 оны 3 дугаар сараас бий болж ашиглагдаж эхлэсэн. Уг мэдээлэлд Зөрчлийн хэрэгт холбогдох

- Зөрчил
- Торгох
- Баривчлах
- Эрх хасах зэрэг мэдээллүүд орж байгаа болно.

Нэгдсэн тайлан боловсруулах чиглэлээр ихээхэн ажлууд хийгдэж байгаа ба тухайлбал, тайлан тоо боловсруулах технологийн шийдэл боловсруулж ашиглаж эхлэв. Тайлан тоо мэдээ гаргах технологийн шийдэл, түүнд ашиглагдах програм хангамж, системүүдийн суурилуулалт тохируулгуудыг хийж дуусган ажилд оруулсан. Энэ үйл ажиллагаанд Oracle OBIEE сервер ашиглах бөгөөд орчин бүрдүүлж тохируулга хийж ажиллагаанд оруулсан. Үүнд:

- Oracle RDBMS
- Weblogic server
- Fusion middleware
- OBIEE сервер болон домайны тохируулга хийсэн

Энэхүү төлөвлөгөөт олон ажлын дараа гэмт хэргийн болон зөрчлийн нэгдсэн тайлан гаргаж, дүн шинжилгээ хийх боломж бүрэн бүрдэх юм.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 15/1,
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,
E-mail: gpo@prokuror.mn

2017.12.27 № 8/28
танай 2017.12.15 -ны № 01/1953 -т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
С.ОЮУНБИЛЭГ ТАНАА**

“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбогдуулан тусгайлан гаргах саналгүй болно.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ТУСЛАХ ПРОКУРОР, ДҮН ШИНЖИЛГЭЭ,
СУДАЛГАА, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАТ-ОРШИХ

УХГ0027 0120151

06008071



Тайлбар-аас саналд өгсөн тайлбар

Ирсэн саналын дугаар	Аудитын тайланд саналыг тусгасан эсэх	ҮАГ-ын тайлбар
Ерөнхий дүгнэлтийн хүрээнд		
Тайлбар №1	ХЗДХЯ-с аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналд “хууль тогтоомжийн төсөл боловсруулах, түүнтэй холбогдон гарах бусад үйл ажиллагааг санхүүжүүлсэн асуудлыг” залруулах саналыг ирүүлсэн боловч хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг зарцуулах чиглэлийг тодорхой заасан, мөн 19 дүгээр зүйлийн 19.4-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэж заасны дагуу тайланд өөрчлөлт оруулж залруулах шаардлагагүй гэж үзэв.	ХЗДХЯ-нд үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулагдсан төсөвт гадаад томилолт, дотоод сургалт, мэдээлэл сурталчилгаа хийх зэрэг зардлын төсөв батлагдсан байхад ХЗДХЯ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвөөс дээрх зардлуудыг санхүүжүүлсэн байна. ХЗДХЯ нь “Хуулийн төсөл боловсруулах” ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамааруулж болохоор тайлбарлаж байгаа боловч энэ нь ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 ⁴⁵ , 19.3.2 ⁴⁶ , 19.3.3 ⁴⁷ , 19.3.4 ⁴⁸ , 19.3.5 ⁴⁹ , 19.3.6 ⁵⁰ дахь заалтуудад тусгагдаагүй байна. Аудитаар 2015-2017 онд ХЗДХЯ-ны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийн зарцуулалтыг авч үзэхэд тус зардлаас хуулийн төсөл боловсруулахад 66.8 сая төгрөг буюу 5.8 хувийг, гадаад томилолтод 159.2 сая төгрөг буюу 13.7 хувийг, зочин хүлээн авалтад 67.8 сая төгрөг буюу 5.8 хувийг, хурал зөвлөгөөнд 128.8 сая төгрөг буюу 11.1 хувийг, орчуулгад 11.3 сая төгрөг буюу 1 хувийг, дотоод сургалтад 545.9 сая төгрөг буюу 47.9 хувийг, хөрөнгө оруулалтад 113.4 сая төгрөг буюу 9.8 хувийг, яамны бусад үйл ажиллагаа, хуульд заагаагүй урамшуулал, хуульд заагаагүй сурталчилгаа зэрэгт 57.1 сая төгрөг буюу 4.9 хувийг тус тус санхүүжүүлж, нийт зардлын 39.0 хувь буюу 1,124.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тайлангийн төслийн 24 дүгээр хуудасны 3.9 дэх хэсэгт тусгаж, зориулалт бус зардлыг хавсралтаар үзүүлэв.
Тайлбар №2	УИХ-ын 37 дугаар тогтоолын хувьд: Аудитын тайланд эдгээр арга хэмжээний талаар дурьдаагүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.	УИХ-ын 37 дугаар тогтоолын 5 дугаар зорилтын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим арга хэмжээний талаар тайланд тусгагдаагүй болно.
	ЗГ-ын 2012 оны 120 дугаар тогтоолын хувьд: Аудитын тайланд батлагдаагүй баримт бичгийн зүйл заалтыг үндэслээгүй болно.	ЗГ-ын 2012 оны 120 дугаар тогтоолоор “ <u>Монгол Улсын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр</u> ” гэсэн баримт бичиг батлагдаагүй байна.
	ЗГ-ын 2012 оны Хөтөлбөр батлах тухай 252 дугаар тогтоолын хувьд: Аудитын тайлангийн агуулгад тусгагдаагүй тул саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзэв.	“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр” -ийн хэрэгжилттэй аудитын явцад танилцсан бөгөөд энэ чиглэлээр хийсэн ажлын талаар тайланд тусгагдаагүй болно.
	ЗГ-ын 2012 оны Хөтөлбөр батлах тухай 257 дугаар тогтоолын хувьд: Аудитын тайлангийн төслийн 12 дугаар хуудасны 1.14-1.18 дахь хэсэгт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй зарим арга хэмжээний талаар оруулсан болно.	Аудитын тайланд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн цагдаагийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд төсөв, хөрөнгийг зохицуулсан хуулийн харилцан нийцэлгүй заалтууд нөлөөлж буй тухай тусгасан.

⁴⁵ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх

⁴⁶ Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах;

⁴⁷ Энэ хуулийн 13 дугаар зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах;

⁴⁸ Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;

⁴⁹ Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх;

⁵⁰ Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх



	3Г-ын 2011 оны Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 58 дугаар тогтоолын хувьд: 3Г-ын 2011 оны 58 дугаар тогтоол хүчингүй болсон бөгөөд тус тогтоолыг үндэслэсэн зүйл заалт тайланд ороогүй тул тайлбарыг хүлээн авах шаардлагагүй гэж үзлээ.	3Г-ын 2011 оны Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 58 дугаар тогтоол хүчингүй болсон учир 3Г-ын 2012 оны Хөтөлбөр батлах тухай 257 дугаар тогтоолыг үндэслэж дээр дурьдсан олон нийтийн цагдаагийн үүрэг оролцооны асуудлаар тайланд зарим агуулагыг тусгасан.
	Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2015, 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хувьд: Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2015, 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт үр дүнд хийсэн аудитын тайлангууд тус бүр гарсан тул уг тайланд нэмэлтээр дурьдах шаардлагагүй гэж үзэж байна.	Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2015, 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Хууль зүйн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтэд ҮАГ-аас 2016, 2017 онд аудит хийж тайланг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн.
	УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолын хувьд: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зорилтууд хэрэгжээгүй талаар аудитын тайланд тусгаж, 2 дугаар бүлэгт оруулсан болно.	ХЗДХЯ болон ЦЕГ-с аудитыг гүйцэтгэх үе шатанд 3Г-ын 2016-2020 оны хөтөлбөрт 5 дугаар зорилтын хүрээнд тусгагдсан арга хэмжээнүүд хэрэгжихгүй байгаа талаар санал тайлбар ирүүлсэн болно.
	3Г-ын 2016 оны 121 дүгээр тогтоолын хувьд: Тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн зарим хөтөлбөрийн биелэлт хангалтгүй байгааг аудитын тайлангийн 2 дугаар бүлэг 19 дүгээр хуудаст тусгасан тул нэмэлт тайлбар оруулах шаардлагагүй гэж үзэв.	Тус тогтоолоор батлагдсан “Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдлэж, залуучуудыг хөгжиж, суралцах хөгжих таатай орчинг бүрдүүлэх” тус зорилтын хүрээний зарим ажлын биелэлтийг хариуцсан төрийн зарим байгууллагуудын үйл ажиллагаа хангалтгүй байгаа талаар тайланд тусгагдсан.
“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал”-ын ангилалд батлуулсан талаар	Аудитын тайлангийн 21 дүгээр хуудас, 3 дугаар бүлгийн 3.2 дахь хэсэгт тодорхой дурьдсан болно.	Аудитын тайланд аймаг, нийслэлийн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвөө хуульд нийцүүлэн бодитой төлөвлөдөггүй, Сангийн яам ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт нийцүүлэн төсвийг хянадаггүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдгаас шалтгаалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах төсөв дутагдаж, зорилтод үр дүнд хүрэх боломжийг хязгаарласан тухай оруулсан болно.
“Төсвийн зарлагын Эдийн засгийн ангилал”-ын талаар	ХЗДХЯ-аас ирүүлсэн тайлбар 1-тэй санаа давхардсан тул хүлээн авах шаардлагагүй гэж үзэв.	
Тайлбар №3	Олон улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өөрийн орны хуулийн салбарт хэрэгжүүлж буй сайн жишээнүүдийг аудитын тайлангийн 2 дугаар бүлгийн 2.7-2.8 тусгасан.	Хууль, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж буй шинэ дэвшилтэт аргуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөлд нэмэлтээр оруулан батлуулах, ашиглаж байгаа арга, хэлбэрүүдээс нөхцөл байдалд нийцүүлэн төрийн бодлогоор дэмжих, эрх зүйн зохицуулалт хийх, хөрөнгө санхүүжилтийн боломжит эх үүсвэрээр хангах замаар хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай байгаа талаар тусгасан.
	Яам болон бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны тайлантай тухай бүрт нь танилцсан бөгөөд статистик тоо, мэдээлэл, бүрийг аудитын тайланд тусгах шаардлагагүй гэж үзсэн.	Саналд тусгасан яам болон ЦЕГ бусад хууль сахиулах чиглэлээр аудитын хүрээнд хамрагдсан байгууллагуудын 2015-2017 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ бүртэй танилцсан бөгөөд энэ чиглэлээр огт ажил хийгдээгүй мэт утга агуулга тайланд дурьдагдаагүй болно.
Галт зэвсгийн тухай хуулийн дагуу ажлын хэсэгт урамшуулал олгох асуудалын талаар	Энэ нь тайлангийн 3 дугаар бүлгийн 23 дугаар хуудсаны 3.9 дэхь хэсэгт дурьдагдсан.	ГХУСТХ-ийн 19.3.3-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон иргэн, ААН-д урамшуулал олгоно” заасан боловч “Галт зэвсгийн тухай хууль”-ийн төслийг шинэчлэн найруулах ажлын хэсэгт нийт 1.62 сая төгрөгийн урамшуулал



		олгосон нь хуулийн заалттай нийцэхгүй байна.
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гадаад оронд томилолт, гадны зочинг хүлээн авах, гэрээ хэлэлцээр байгуулах талаар	ХЗДХЯ-с ирүүлсэн тайлбар 1-тэй санаа давхардсан тул хүлээн авах шаардлагагүй гэж үзэв.	
Архидан согтуурахтай тэмцэх сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар	Баримтаар нотлогдогдсон илрүүлэлт тул саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд тайланд найруулгын өөрчлөлт оруулав.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13 ² .6, тус сангийн дүрмийн 3.1.2-т сангийн зөвлөл нь төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулж, сангийн хөрөнгийг зарцуулахаар заасан. Гэтэл тус яамны төрийн нарийн бичгийн дарга 2016 оны А/13 дугаар тушаалаар сонгон шалгаруулах комиссыг бүрэлдэхүүнийг батлан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг шалгаруулсан нь Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрмийн 3.1.2 -ыг зөрчсөн.
Дотоод аудитын талаар	Саналыг хүлээн авах боломжгүй. Аудитын тайлангийн 26 дугаар хуудасны 3.26 дахь хэсэгт дурьдсан болно.	ХЗДХЯ-ны Дотоод аудитын газраас 2015-2017 онд зөвхөн Архидан согтуурахтай тэмцэх сан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт хийсэн бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд бүхэлд нь хяналт хийгдээгүй.
Бүлэг 1.		
Тайлбар №1	Саналыг хүлээн авч тайланд найруулгын өөрчлөлт оруулав.	ГХУССА33-ийн 2015 -2016 он 2017 оны үйл ажиллагааг тус бүр салгаж тайланд оруулав.
ТББ-тай хийсэн гэрээний талаар	Саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзэв.	Тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.22- 1.23- т нотлох баримтад үндэслэж тодорхой тусгасан болно.
Бүлэг 2.		
Тайлбар №1	Саналыг хүлээн авч дараах байдлаар тайланд залруулга хийв.	Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гэмт хэргийг төрөлжүүлсэн 20 бүлэгт ангилан үзэж байгаа бөгөөд 2016 оны байдлаар эдгээр гэмт хэргийн улмаас 27.7 мянган хүн хохирч, 162.9 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирсан байна.
Тайлбар №2	Саналыг хүлээн авч дараах байдлаар тайланд залруулга хийв.	2017 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулиар зөрчлийг тодорхойлсон нэгдсэн ойлголттой болсон хэдий ч эдгээр зөрчлийн тоо бүртгэл, статистик мэдээлэл боловсруулалт, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг судлах, дүн шинжилгээ хийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах бүтэц, тогтолцоо бүрдээгүй байна.
Тайлбар № 3	Холбогдох тайлбарыг аудитын тайлангийн 2 дугаар бүлгийн 16 дугаар хуудаст оруулсан тул энэхүү саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзэв.	Саналд дурдсан хуулиудад зөрчлийн статистик мэдээ гаргах нь Прокурорын байгууллагын чиг үүрэг гэж заагаагүй бөгөөд бүтэц тогтолцооны тухай дурдсан.
Тайлбар №4	Аудитын тайланд Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар дурьдаагүй тул саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзэв.	Аудитын тайланд Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар дурьдаагүй.
Тайлбар №5	Замын хөдөлгөөнд мөрдөж буй дүрэм шинэчлэгдэн батлагдаагүй бөгөөд тайлбарыг хүлээн авах шаардлагагүй гэж үзэв.	Монгол Улсын нутаг дэвсгэр дээр замын хөдөлгөөнд оролцогчид 2004 онд батлагдсан дүрмийг мөрдөж байгаа бөгөөд 2017 оны 10 дугаар сарын байдлаар уг дүрэм шинэчлэгдэн батлагдаагүй байсан.
Тайлбар №6	Аудитын явцад "Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам" хараахан батлагдаагүй байсан тул саналыг хүлээн авах боломжгүй гэж үзэв.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэсээс 2016-2017 онд батлагдсан холбогдох журмуудыг танилцуулсан боловч тухайн үед "Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг



		санхүүжүүлэх журам" хараахан батлагдаагүй гэсэн тайлбарыг тус хэлтсээс ирүүлсэн.
Тайлбар №7	Аудитын гүйцэтгэлийн явцад хамтарсан багийн хамтын үйл ажиллагааны үр дүнд далд хэлбэртэй үйлдэгдэж буй хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлийг илрүүлж таслан зогсоосон, холбогдох арга хэмжээ авч ажилласан тоо мэдээлэл, жишээ баримтаар нотлогдоогүй тул хүлээн авах боломжгүй.	Хамтарсан баг ажиллуулах нь далд орчинд үйлдэгдэж буй хэрэг зөрчлүүдийг илрүүлэх, таслан зогсоох оновчтой арга хэлбэр болж чадаагүй нь удаа дараалан бүртгэгдэж буй хүчирхийлэл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэргүүдийн гаралт буурахгүй байгаа талаар тайлангийн төсөлд оруулсан болно.
Тайлбар №8	Саналд дурьдсан арга хэмжээг аудитын гүйцэтгэх үе шат дууссаны дараа буюу 2017 оны 12 дугаар сард 1 удаа зохион байгуулсан мөн аудитын тайланд 1 удаагийн арга хэмжээгээр бус бодлогын түвшинд анхаарч ажиллахыг зөвлөмжөөр өгсөн тул тайланд тусгах шаардлагагүй гэж үзлээ.	Аудитын явцад зарим дүүргийн цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааг шалгахад холбогдох шалгалтын тайлан мэдээ, баримт материал шаардлага хангахгүй байсан бөгөөд саналд дурьдсан арга хэмжээг аудитын гүйцэтгэх үе шатны ажил дууссаны дараа буюу 2017 оны 12 дугаар сард зохион байгуулсан байгаа тул аудитын хугацаанд хамрахгүй тул тайланд оруулах боломжгүй байна.
Тайлбар №9	Тайланд салбарын алба хаагч, мэргэжилтнүүдийг урьдчилан сэргийлэх чиг үүргээ огт хэрэгжүүлж ажилладаггүй гэсэн агуулга тусгагдаагүй тул тайлбарыг тусгах шаардлагагүй гэж үзлээ.	Тайлангийн төсөлд ХСИС-ийн бүтэц, дүрэм, хичээлийн хөтөлбөрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр төлөвлөгөө тусгагдахгүй байгаа нь энэ чиглэлээр дагнан ажиллах боловсон хүчин хуулийн салбарт байхгүй талаар дурьдсан.
Тайлбар №10	Аймаг, орон нутгийн аудитын байгууллагын шалгалтын явцад салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангалтгүй, ГХУСА33-ийн ажлын албанаас мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаагаар хангаж ажиллаагүй зөрчлүүд тайлангийн төслийн 20 дугаар хуудасны 2.25 дахь хэсэгт дурьдагдсан тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.	Аудитын явцад шаардлагатай мэдээллийг цуглуулах зорилгоор хууль сахиулах зарим төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудаас авсан санал асуулгад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын алба хууль сахиулах бусад байгууллагуудыг удирдлага зохион байгуулалтаар хангасан, бие даасан тодорхой хариулт ирүүлээгүй.
Тайлбар №11	2017 оны эхний хагас жилд байгуулагдсан дэд зөвлөлүүдийн ажлын тайлан гараагүй байсан тул тайлбарыг оруулах шаардлагагүй гэж үзлээ.	Аудитын гүйцэтгэлийн явцад ХЗДХС-ын тушаалаар 2017 онд байгуулсан дэд зөвлөлүүд журмын дагуу сайдад ажлаа тайлагнаж эхлээгүй байсан.
Тайлбар №12	ГХУСТХ-ийн шинэчилсэн найруулгын талаар аудитын тайланд тусгаагүй тул саналыг хүлээн авах шаардлагагүй гэж үзэв.	Аудитын тайлантай холбоогүй мэдээлэл байна.

ДҮГНЭЛТ:

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд хийсэн дүгнэлт

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоог бүрэн бүрдүүлээгүй нь хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөг бууруулж, гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй байна.

- Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн судалгааг нэгдмэл байдлаар дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, бодлого боловсруулах чиг үүргийг орон тооны бус бүтцэд харьяалуулснаас шалтгаалж, тус үйл ажиллагаа байнгын бөгөөд тасралтгүй ажиллаж чадахгүй, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нэгдмэл бодлогогүй байна.
- Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг хангалттай зохион байгуулж ирээгүй нь гэмт хэргийн гаралт буурахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.
- Цагдаагийн албан хаагчдын ажлын ачаалал их, ОНЦ-г бүрэн орон тоогоор ажиллуулахгүй байгаагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хийгдэх боломж хязгаарлагдсан байна.
- ХЗДХЯ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ТББ-уудтай байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээний гүйцэтгэлийг дүгнэдэггүйгээс үр дүнг үнэлэх боломжгүй байна.
- Төсвийг зориулалт бусаар зарцуулснаас шалтгаалж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн төлөвлөгөөт ажил бүрэн хэрэгжээгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэхэд хийсэн дүгнэлт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байна.

- Зөрчлийн тухай хуулиар зөрчлийг тодорхойлсон нэгдсэн ойлголттой болсон хэдий ч эдгээр зөрчлийн тоо бүртгэл, статистик мэдээлэл боловсруулалт, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг судлах, дүн шинжилгээ хийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах бүтэц, тогтолцоо бүрдээгүй байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн туршлагуудыг дэмжих бодлого, эрх зүйн зохицуулалтгүйгээс хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ажлын албаны үйл ажиллагаа тогтворгүй, байнгын бус, үйл ажиллагааг зохистой төлөвлөж ирээгүй нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байх шалтгаан болж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэхэд хийсэн дүгнэлт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг арга хэмжээ бүрээр төлөвлөн баталж, хянаагүйгээс хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- Аймаг, нийслэлийн ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвөө хуульд нийцүүлэн бодитой төлөвлөдөггүй, Сангийн яам ГХУСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт нийцүүлэн төсвийг хянадаггүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдгаас шалтгаалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах төсөв дутагдаж, зорилтод үр дүнд хүрэх боломжийг хязгаарласан байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.
- ХЗДХЯ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, батлаагүй, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж байгаагүйгээс нийт зардлын 39.0 хувийг зориулалт бусаар зарцуулжээ.
- ХЗДХЯ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн зарцуулалтад тавих хяналт сул байгаа нь батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**Зөвлөмж:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, төсөв санхүүг орон тооны бус, тогтворгүй үйл ажиллагаатай бүтцэд харьяалуулж байгаа өнөөгийн тогтолцоог өөрчлөх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, зохицуулалтыг төвлөрүүлэн хэрэгжүүлдэг эргэх холбоо бүхий үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх;
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулсан төсвийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөтгөж зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах тогтолцоог бүрдүүлэх.

УИХ-ын гишүүн, Хууль зүй дотоод хэргийн сайд, ГХУСАЗЗ-ийн дарга Ц.Нямдоржид:

1. ХЗДХЯ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэрээгээр ажиллах ТББ-уудыг хууль тогтоомжид заасны дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэсэн ажлыг дүгнэж байх;
2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох чиг үүргийн давхардлыг арилгах;
3. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх сайн туршлагуудыг дэмжих бодлого, эрх зүйн зохицуулалтаар хангах;
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэх;
5. ХЗДХЯ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөн баталж тухай бүр хяналт тавьж ажиллах;
6. Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх,

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

1. Төсвийн тухай хуульд нийцүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнг харгалзан аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг хянан батлуулж байх,
2. “Эдийн засгийн ангилалд өөрчлөлт оруулах замаар ХЗДХЯ-ны хуулийн төсөл боловсруулах зардлыг тусад нь хянаж батлах,
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас гадаад томилолт болон хуулиар зөвшөөрөгдөөгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх,

Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга нарт:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсвийг хуульд заасан нөхцөл журмын дагуу батлан аймаг, сумын Засаг даргын мэдэлд хуваарилан зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах,
2. Олон нийтийн цагдааг идэвхтэй ажиллуулахад шаардлагатай төсөв хөрөнгийг шийдэх.



Хавсралт №1

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зарцуулсан зардлын судалгаа 2015 он

№	Захиран зарцуулагч	Төсвийн эх үүсвэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Үүнээс							Зориулалт бусаар зарцуулсан зардал
						Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх	Эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах;	Тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх	Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх	Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх	Бусад	
1	Архангай	ОНТ	56.2	55.9	0.3	25.7	6.6			7.9		15.7	
2	Баян-Өлгий	ОНТ	19.2	13.0	6.2	8.6	2.2						2.2
3	Баянхонгор	ОНТ	79.7	71.7	8.0	30.3	11.1	4.2	-	10.3	0.4	2.4	13.0
4	Булган	ОНТ	46.2	42.8	3.3	9.3	17.8	-	-	7.5	-	8.3	-
5	Говь-Алтай	ОНТ	49.3	42.4	6.9	4.8	19.1	4.6	-	0.2	-	0.4	13.3
6	Дорноговь	ОНТ	74.4	71.6	2.8	7.9	60.2	1.0	-	1.9	-	-	0.6
7	Дорнод	ОНТ	46.6	89.2	(42.6)	32.9	-	-	-	50.2	-	6.1	-
8	Дундговь	ОНТ	31.0	30.4	0.6	9.8	14.5	-	-	0.2	-	-	5.9
9	Завхан	ОНТ	46.9	58.6	(11.7)	16.2	11.5	-	-	-	-	19.1	11.8
10	Өвөрхангай	ОНТ	83.8	83.5	0.3	75.1	2.6	0.1	-	-	-	0.8	5.0
11	Өмнөговь	ОНТ	27.6	19.4	8.3	10.0	-	0.3	-	2.0	-	7.1	-
12	Сүхбаатар	ОНТ	28.5	42.6	(14.1)	9.2	1.0	1.0	-	-	-	10.8	20.6
13	Сэлэнгэ	ОНТ	104.2	87.7	16.5	20.1	49.0	0.1	-	1.9	0.1	6.8	9.7
14	Төв	ОНТ	76.4	65.5	11.0	35.1	11.8	5.6	-	1.5	3.2	8.3	-
15	Увс	ОНТ	59.3	27.4	31.9	14.0	0.9	2.0	-	1.0	-	9.4	0.0
16	Ховд	ОНТ	61.8	54.9	6.9	17.1	17.5	-	1.6	6.4	-	-	12.3
17	Хөвсгөл	ОНТ	46.1	32.2	13.9	20.9	4.7	2.7	-	1.2	1.7	0.6	0.6
18	Хэнтий	ОНТ	146.8	73.7	73.0	18.7	1.7	1.6	-	13.0	2.2	33.6	2.9
19	Дархан-Уул	ОНТ	101.6	92.8	8.8	20.1	53.7	4.6	-	13.8	-	0.6	-
20	Орхон	ОНТ	253.7	215.1	38.6	54.0	77.7	1.6	-	51.7	-	30.1	-
21	Говьсүмбэр	ОНТ	41.1	25.2	15.9	5.0	17.6	0.1	-	-	-	0.0	2.4
22	Нийслэл	ОНТ	3,240.0	2,450.8	789.2	233.8	1,438.6	41.2	-	479.5	29.4	40.1	188.2
Аймаг, нийслэлийн дүн			4,720.4	3,746.2	974.2	678.6	1,819.7	70.7	1.6	650.1	36.9	200.2	288.4
23	ХЗДХЯам	Улсын төсөв	607.9	445.2	162.7	310.4	-	-	-	-	-	34.4	100.4
Нийт дүн			5,328.3	4,191.4	1,136.9	989.0	1,819.7	70.7	1.6	650.1	36.9	234.6	388.8



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зарцуулсан зардлын судалгаа 2016 он

№	Захиран зарцуулагч	Төсвийн эхүүсвэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Үүнээс							Зориулалт бусаар зарцуулсан зардал
						Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх	Эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах;	Тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх	Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх	Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх	Бусад	
1	Архангай	Орон нутгийн төсөв	67.0	66.4	0.6	25.0	12.2			13.4	0.1	15.7	
2	Баян-Өлгий	Орон нутгийн төсөв	20.0	19.9	0.1	3.7							16.2
3	Баянхонгор	Орон нутгийн төсөв	104.4	104.3	0.1	54.9	8.1	8.5	-	13.4	0.1	6.9	12.5
4	Булган	Орон нутгийн төсөв	56.8	53.5	3.3	13.0	19.6	3.9	-	7.2	-	9.8	-
5	Говь-Алтай	Орон нутгийн төсөв	57.3	55.0	2.3	9.7	17.5	0.2	-	-	-	1.5	26.2
6	Дорноговь	Орон нутгийн төсөв	63.6	63.3	0.3	14.9	36.3	0.2	-	4.7	-	0.5	6.7
7	Дорнод	Орон нутгийн төсөв	68.5	88.3	(19.8)	56.1	2.2	-	-	20.0	-	10.0	-
8	Дундговь	Орон нутгийн төсөв	36.0	35.0	1.0	6.6	17.1	1.4	-	5.5	-	-	4.4
9	Завхан	Орон нутгийн төсөв	40.4	48.6	(8.2)	7.8	0.4	-	-	-	-	28.4	12.0
10	Өвөрхангай	Орон нутгийн төсөв	78.5	77.7	0.8	70.7	3.9	0.1	-	1.4	-	0.8	0.9
11	Өмнөговь	Орон нутгийн төсөв	49.7	46.3	3.4	21.4	0.9	2.1	-	12.8	1.0	8.1	-
12	Сүхбаатар	Орон нутгийн төсөв	55.0	53.5	1.6	6.9	-	1.6	-	23.9	-	14.6	6.5
13	Сэлэнгэ	Орон нутгийн төсөв	54.0	52.5	1.5	20.0		1.1		4.9	0.1	13.9	12.5
14	Төв	Орон нутгийн төсөв	93.8	89.0	4.8	45.4	9.2	10.9	-	9.8	2.8	10.9	-
15	Увс	Орон нутгийн төсөв	60.8	56.3	4.5	11.2	1.8	5.7		11.8		22.9	2.9
16	Ховд	Орон нутгийн төсөв	59.2	65.2	(6.0)	12.6	15.7		1.6	5.4		16.2	13.7
17	Хөвсгөл	Орон нутгийн төсөв	56.1	55.3	0.9	25.2	10.7	8.3	-	3.7	2.1	2.9	2.3
18	Хэнтий	Орон нутгийн төсөв	181.1	113.9	67.2	32.9	5.0	1.6	-	21.5	10.1	35.0	7.8
19	Дархан-Уул	Орон нутгийн төсөв	87.7	80.8	6.9	16.2	43.7	4.8	-	15.1	-	1.0	
20	Орхон	Орон нутгийн төсөв	251.2	252.3	(1.1)	47.1	114.0	32.8	-	10.9	-	45.8	1.7
21	Говьсүмбэр	Орон нутгийн төсөв	49.7	48.1	1.6	14.7	19.4	0.1	-	12.0	-	1.7	0.3
22	Нийслэл	Орон нутгийн төсөв	5,240.0	5,268.2	(28.2)	995.0	2,028.3	62.7	-	1,763.8	5.4	58.0	355.1
Аймаг, нийслэлийн дүн			6,830.8	6,793.4	37.3	1,511.0	2,366.0	145.9	1.6	1,961.1	21.7	304.5	481.7
23	ХЗДХЯам	Улсын төсөв	1,367.0	1,366.6	0.4	637.5		1.6				336.2	391.3
24	Цагдаагийн ерөнхий газар	Улсын төсөв	60.0	53.1	6.9	14.2				33.2		5.7	
Нийт дүн			8,257.8	8,213.1	44.6	2,162.7	2,366.0	147.5	1.6	1,994.3	21.7	646.4	873.0



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зарцуулсан зардлын судалгаа 2017 он

№	Захиран зарцуулагч	Төсвийн эх үүсвэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Үүнээс							/сая төгрөгөөр/
						Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх	Эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах;	Тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх	Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх	Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх	Бусад	Зориулалт бусаар зарцуулсан зардал
1	Архангай	Орон нутгийн төсөв	63.4	32.2	31.2	10.6	8.5			6.0		7.1	
2	Баян-Өлгий	Орон нутгийн төсөв	10.0	9.3	0.7	3.8							5.5
3	Баянхонгор	Орон нутгийн төсөв	91.1	44.3	46.8	24.4	4.1	2.3	-	4.8	0.2	2.2	6.2
4	Булган	Орон нутгийн төсөв	46.9	29.8	17.1	11.5	6.2	0.1	-	6.9	-	5.1	-
5	Говь-Алтай	Орон нутгийн төсөв	51.6	32.7	19.0	7.3	15.1	-	-	-	-	0.9	9.3
6	Дорноговь	Орон нутгийн төсөв	77.7	37.9	39.8	3.8	32.0	0.4	-	-	-	1.2	0.5
7	Дорнод	Орон нутгийн төсөв	67.7	50.3	17.4	25.1	3.2	-	-	17.1	-	4.9	-
8	Дундговь	Орон нутгийн төсөв	30.7	8.5	22.2	1.5	6.8	0.1	-	-	-	-	-
9	Завхан	Орон нутгийн төсөв	53.0	40.7	12.3	10.1	-	-	-	2.5	-	26.3	1.8
10	Өвөрхангай	Орон нутгийн төсөв	89.9	41.0	48.8	35.2	1.8	0.3	-	0.0	-	-	3.7
11	Өмнөговь	Орон нутгийн төсөв	72.6	20.4	52.2	8.0	0.1	0.5	-	5.8	0.3	5.6	-
12	Сүхбаатар	Орон нутгийн төсөв	47.2	15.9	31.3	3.8	-	-	-	8.7	-	2.0	1.4
13	Сэлэнгэ	Орон нутгийн төсөв	74.4	48.6	25.8	10.6	0.1	0.3	-	27.0	0.2	3.5	6.9
14	Төв	Орон нутгийн төсөв	73.7	31.1	42.6	14.7	5.4	2.1	-	4.7	0.6	3.6	-
15	Увс	Орон нутгийн төсөв	31.4	26.8	4.6	8.4	1.2	0.7	-	8.6	-	7.8	-
16	Ховд	Орон нутгийн төсөв	68.1	31.4	36.7	7.1	11.2	-	0.8	1.7	-	6.0	4.6
17	Хөвсгөл	Орон нутгийн төсөв	54.4	18.6	35.8	10.1	1.8	1.2	-	4.7	0.3	0.1	0.4
18	Хэнтий	Орон нутгийн төсөв	105.0	42.6	62.4	16.4	2.3	1.3	-	11.9	1.9	8.6	0.1
19	Дархан-Уул	Орон нутгийн төсөв	112.2	42.5	69.7	4.1	22.0	4.7	-	10.7	-	1.0	-
20	Орхон	Орон нутгийн төсөв	146.6	571.8	(425.2)	38.6	58.3	-	-	17.6	-	24.8	432.5
21	Говьсүмбэр	Орон нутгийн төсөв	47.5	41.7	5.8	5.4	8.6	1.1	-	25.7	-	-	0.9
22	Нийслэл	Орон нутгийн төсөв	5,240.0	2,347.2	2,892.8	242.0	1,166.4	10.8	-	847.6	-	-	80.3
Аймаг, нийслэлийн дүн			6,655.0	3,565.3	3,089.7	502.5	1,355.2	26.0	0.8	1,012.1	3.5	110.9	554.2
23	ХЗДХЯам	Улсын төсөв	1,800.8	938.1	862.7	127.7		27.8				149.5	633.1
24	Цагдаагийн ерөнхий газар	Улсын төсөв	88.0	2.6	85.4							2.6	
Нийт дүн			8,543.8	4,506.0	4,037.8	630.2	1,355.2	53.8	0.8	1,012.1	3.5	263.0	1,187.3



Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчил гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Нэр
1	ГХУСАЗЗ-ын ажлын албыг 2012 онд татан буулгаснаас шалтгаалж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэгдмэл бодлого алдагдсан байна.	-	Зөвлөмж	2012 онд Хууль зүйн сайд	Х.Тэмүүжин
	Гэмт хэргээс хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах шинжилгээ судалгааны ажлыг эрхлэх эрдэм шинжилгээний байгууллагыг татан буулгасан	-	Зөвлөмж	2016 онд ХЗДХС	С.Бямбацогт
	ГХУСАЗЗ нь журамд заасан хугацаанд хуралдаагүй.	-	Зөвлөмж	ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан	Ж.Баярцэцэг
2	ХЗДХЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Ж.Баярцэцэг нь 2016 оны А/13 дугаар тушаалаар сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг батлан төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг шалгаруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 131.8 сая төгрөгийг зарцуулсан нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13.6, Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.	131.8	Зөвлөмж	ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан	Ж.Баярцэцэг
3	2015-2016 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг зориулалт бусаар зарцуулсан.	267.5	Зөвлөмж	ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан	Ж.Баярцэцэг
4	2016-2017 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг зориулалт бусаар зарцуулсан.	857.3	Зөвлөмж	2016 оны 9 дүгээр сараас ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	Г.Баясгалан
5	ХЗДХЯ нь хууль сурталчлах, олон нийтэд эрх зүйн боловсрол олгох зорилготой нийтлэл гаргах чиглэлээр хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулсан боловч “Ховд аймагт оношлогооны шинэ төв барьна”, “Сайдын зөвлөлийн хуралдаан боллоо”, “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг байгууллагуудын дунд тэмцээн болов” зэрэг мэдээ нийтлүүлэн яамны үйл ажиллагаа болон сайдын ажлыг сурталчилж 66.8 сая төгрөгийг гэрээнд зааснаас өөр үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.	66.8	Зөвлөмж	ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Г.Баясгалан
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн зарим төсөл, хөтөлбөрийн гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнээгүй байхад гэрээний төлбөрийг олгож, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр төсвийг зарцуулж, нягтлан бодох бүртгэл, тайланд тусгасан байна.	-	Зөрчил арилгуулж, хариуцлага тооцуулах тухай 01/36 САГ-ГАГ/2017/09-ГА дугаартай албан шаардлага	ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Н.Цэвэлмаа

МОНГОЛ УЛСЫН Ерөнхий аудиторын тушаал

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны нэгдүгээр улиралд Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/, Хууль зүй, дотоод хэргийн сайд /Ц.Нямдорж/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /И.Туяадарь/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны
03 дугаар сарын 03-ний өдрийн А/45 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Төлбөр, зөрчлийн товч утга	Дугаар	Төлбөрийн актын дүн	Албан шаардлагын дүн
	Төлбөр, зөрчл байгууллага	Албан тушаал				
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	Төрийн нарийн бичгийн дарга	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ТББ-тай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн зарим төсөл, хөтөлбөрийн гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнээгүй байхад гэрээний төлбөрийг олгож, анхан шатны баримтын бүртгэлгүйгээр төсвийг зарцуулж, НББ, тайланд тусгасан	01/36-САГ-ГАГ/2017/09-ГА	-	-

--- o0o ---

[illegible]



“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

- 56 -



“Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

- 57 -